



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



БОДЛОГЫН ШИЙДЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС АВАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2025 он

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС АВАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: Авлигатай тэмцэх газар
Гүйцэтгэгч: “Бодлогын шийдэл” ТББ

Улаанбаатар хот, 2025 он

Энэхүү тайлан нь “Шударга байдлын үнэлгээ – 2025” судалгааны “Төрийн байгууллагын шударга байдлын үйлчлүүлэгчдээс авах судалгаа”-ны тайлан юм. Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг АТГ-аас хараат бус байдлаар гүйцэтгэсэн бөгөөд “Бодлогын шийдэл” ТББ-аас явуулсан судалгаанд оролцогчдын үнэлгээний үр дүнд үндэслэгдсэн болно.

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Доктор Ж.Баттулга

Тайлан боловсруулсан: Доктор П.Буяннэмэх

Мэдээлэл цуглуулалтын баг:

Г.Оюун-Эрдэнэ
Ж.Сувдаа
А.Энхтуяа
О.Балжин
З.Сайнжаргал
Л.Баярцэцэг
Б.Гантөмөр
И.Батхишиг
Б.Нарантуяа
Л.Мишээл
Г.Бадамцэцэг
Д.Итгэлмаа
Баяртуяа
Номундарь
Н.Эрдэнэцэцэг

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	7
ТАЛАРХАЛ	8
ХУРААНГУЙ.....	9
БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ.....	11
1.1 Шударга байдлын үнэлгээний аргачлал	11
1.1.1 Үнэлгээний загвар.....	11
1.1.2 Үнэлгээний утга	11
1.2 Судалгааны хамрах хүрээ.....	13
1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	14
БҮЛЭГ 2. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	15
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	15
2.2 ГШБҮ-ний ерөнхий үр дүн	15
2.2.1 Яамдын ГШБҮ	20
2.2.2 Агентлагуудын ГШБҮ.....	21
2.2.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ	22
2.3. Авлигын эрсдэлийн индекс.....	23
2.3.1 Яамдын авлигын эрсдэлийн индекс	25
2.3.2 Агентлагуудын авлигын эрсдэлийн индекс	26
2.3.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын эрсдэлийн индекс.....	27
2.4 Авлигын индекс.....	29
2.4.1 Яамдын авлигын индекс	30
2.4.2 Агентлагуудын авлигын индекс	31
2.4.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын индекс	33
2.4.4 Чанарын асуултуудын үр дүн	34
2.5 Дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ.....	37
2.6 ГШБҮ-ний гүйцэтгэл бага байгууллагууд.....	39
Бүлэг 3. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН ТӨСӨӨЛӨЛ	48
3.1 Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал	48
3.2 Монгол улс дахь авлигын шалтгаан.....	50
3.3 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн	51
ДҮГНЭЛТ	53
ХАВСРАЛТ	58

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шбү-ний 0-100 оноонд шилжүүлэх	12
Хүснэгт 2. Гадаад шударга байдлын хувьд давтамж, үнийн дүнг оноожуулах	12
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	15
Хүснэгт 4. Гшбү-ний дэд үзүүлэлтүүд, төрийн байгууллагуудын төрлөөр, 2025 он	16
Хүснэгт 5. Гшбү, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	18
Хүснэгт 6. Яамдын гшбү-ний үр дүн, 2024, 2025 онуудыг харьцуулсан үр дүн (2025 оны эрэмбээр)	20
Хүснэгт 7. Агентлагуудын гшбү-ний үр дүн, 2024, 2025 онуудыг харьцуулсан үр дүн (2025 оны эрэмбээр)	21
Хүснэгт 8. Аймаг болон нийслэлийн здтг-уудын гшбү-ний үр дүн, 2024 болон 2025 оныг харьцуулсан үр дүн (2025 оны эрэмбээр)	23
Хүснэгт 9. Яамдын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он	25
Хүснэгт 10. Агентлагуудын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он	26
Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн здтг-уудын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он	28
Хүснэгт 12. Яамдын авлигын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он	30
Хүснэгт 13. Агентлагуудын авлигын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он	32
Хүснэгт 14. Аймаг, нийслэлийн здтг-уудын авлигын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он	33
Хүснэгт 15. А11, а12, а13 асуултуудад өгсөн “тийм” хариултын тоо, байгууллагаар	34
Хүснэгт 16. Авлигыг бууруулах арга хэмжээний санал	36
Хүснэгт 17. Дүүргүүдийн здтг-ын гшбү, онуудаар	37
Хүснэгт 18. Дүүргүүдийн здтг-ын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтийн өөрчлөлт	38
Хүснэгт 19. Дүүргүүдийн здтг-ын авлигын индекс, дэд үзүүлэлтийн өөрчлөлт	39
Хүснэгт 20. Сүхбаатар аймгийн здтг-ын гшбү-ний үзүүлэлтүүд	40
Хүснэгт 21. Өвөрхангай аймгийн здтг-ын гшбү-ний үзүүлэлтүүд	41
Хүснэгт 22. Дорнод аймгийн здтг-ын гшбү-ний үзүүлэлтүүд	43
Хүснэгт 23. Ховд аймгийн здтг-ын гшбү-ний үзүүлэлтүүд	44
Хүснэгт 24. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны гшбү-ний үзүүлэлтүүд	46
Хүснэгт 25. Авлигын түгээмэл байдлын төсөөллийн хариултын хувийн жин, насны бүлгээр	49
Хүснэгт 26. Авлигын ирэх 2 жилийн төсөөллийн хариултын хувийн жин, насны бүлгээр	50
Хүснэгт 27. Монгол улс дахь авлигын үндсэн шалтгаан, 2025	51
Зураг 1. Гшбү, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр, 2025 он	16
Зураг 2. Гшбү, байгууллагын төрлөөр, оноор	17
Зураг 3. Гшбү хамгийн их өөрчлөлттэй байгууллагууд, өөрчлөлт, оноогоор	18
Зураг 4. Авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтээр, сүүлийн 5 жилээр	24
Зураг 5. Авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2025	24
Зураг 6. Авлигын индекс, дэд үзүүлэлтээр, сүүлийн 5 жилээр	29
Зураг 7. Авлигын индекс болон түүний дэд үзүүлэлтүүд, байгууллагын төрлөөр, 2025 он	30
Зураг 8. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив тусалцааг ямар үед үзүүлсэн бэ? (а14)	35
Зураг 9. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив тусалцаа үзүүлэх болсон шалтгаан юу бэ?	36
Зураг 10. Дүүргүүдийн гшбү-ний дэд индексийн үнэлгээ, онуудаар	38
Зураг 11. Монгол улсад авлига хэр түгээмэл байна вэ?, хувиар, сүүлийн 5 жилээр	48
Зураг 12. Ирэх 2 жилд монгол улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ? Хувиар, сүүлийн 5 жилээр	49
Зураг 13. Монгол улс дахь авлига хамгийн их тархсан институци, 2024 болон 2025 он, хариултад эзлэх хувиар	50

Зураг 14. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг хэрхэн үнэлэх вэ?, сүүлийн 5 жилээр	52
---	----

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
ГШБҮ	Гадаад шударга байдлын үнэлгээ
ГШБ	Гадаад шударга байдал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

ТАЛАРХАЛ

“Төрийн байгууллагуудын шударга байдлын талаар үйлчлүүлэгчдээс авах судалгаа” – ны ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож судалгааны арга зүйн зөвлөгөө өгсөн “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олонд, мөн судалгааны тоон мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд, судалгааны тоон мэдээлэл цуглуулалтад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье.

ХУРААНГУЙ

Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ) нь төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын ил тод, хариуцлагатай байдал, ашиг сонирхлын зөрчил, авлигын шууд болон шууд бус илрэлтэй холбоотой иргэд, аж ахуйн нэгжийн үнэлгээг тодорхойлох зорилготой юм.

2025 оны ГШБҮ-ний судалгаанд төрийн захиргааны 81 байгууллагын үйлчилгээг авсан нийт 10,840 иргэн хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 10.4 хувь нь өөрийн байгууллагыг төлөөлөн төрийн байгууллагаар үйлчлүүлсэн бол 89.6 хувь нь хувь хүнээ төлөөлөн үйлчлүүлсэн иргэд байв. Судалгаанд оролцогчдын 46.1 хувь нь эрэгтэй, 53.9 хувь нь эмэгтэй үйлчлүүлэгчид байлаа. Насны бүлгээр авч үзвэл судалгаанд оролцогчдын 3.1 хувийг 20 хүртэл насны иргэд, 16.6 хувийг 20-29 насны иргэд, 31 хувийг 30-39 насны иргэд, 27.9 хувь нь 40-49 насны иргэд, 14.4 хувь нь 50-59 насны иргэд, 6.9 хувь 60-аас дээш насны иргэд хамрагдлаа.

Энэ оны төрийн байгууллагын дундаж үнэлгээг гаргахдаа яам, агентлаг, аймаг ба нийслэлийн ЗДТГ-ууд гэсэн 72 байгууллагаар тооцсон ба нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын ГШБҮ-г тусад нь дүгнэсэн байна. Учир нь дүүргүүдийн ЗДТГ-ыг ШБҮ-ний судалгаанд 2022 оноос эхлэн хамруулсан ба өмнөх жилүүдийн дундаж үнэлгээтэй харьцуулах зорилгоор ийнхүү бүлэглэн тайлагнасан болно.

2025 оны төрийн байгууллагуудын ГШБҮ нь 70.7 болж, өмнөх онтой харьцуулахад 1.6 оноогоор өссөн. ГШБҮ-г *авлигын эрсдэлийн индекс* ба *авлигын индекс* гэсэн хоёр дэд индексээр хэмждэг бөгөөд энэ онд харгалзан 63.4 ба 77.9 оноогоор үнэлэгджээ. Эдгээр нь харгалзан 2.1 ба 1.2 оноогоор тус тус өссөн нь ГШБҮ-г өсгөх нөлөө үзүүлжээ. Индексүүдэд харгалзах 5 дэд үзүүлэлтийн 4 нь өсөлттэй, нэг үзүүлэлт төдийлөн өөрчлөлтгүй гарсан. Хэдийгээр бага зэргийн өсөлттэй үр дүн гарсан боловч үнэлгээний оноо 59.7 – 84.3-ийн хооронд байгаа буюу зарим дэд үзүүлэлт хангалтгүй үнэлгээтэй хэвээр байна. Тухайлбал, байгууллагын ил тод байдал 59.7, хариуцлагатай байдал 67.0, авлигын талаарх төсөөлөл 65.6 гэсэн үнэлгээтэй байгаа нь сайжруулах шаардлага байсаар байгааг харуулж байна.

Энэ оны судалгааны өмнөх оноос ялгарах онцлог үр дүнгүүдээс дурдвал яамдын үнэлгээ өмнөх оноос буурч 69.6 оноонд хүрсэн, агентлагуудын үнэлгээ өсөж 76.4 хүрсэн явдал байна. Харин аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ төдийлөн өөрчлөлтгүй хэвээр буюу бусад төрийн байгууллагын бүлгээс бага үнэлэгдсэн хэвээр байна. Шударга байдал зөрчигдөх болсон шалтгаан, түүнийг сайжруулах арга хэмжээ зэрэг чанарын асуултуудын үр дүн өмнөх онуудтай төстэй буюу цалин хөлс, амьжиргааны түвшин, үнийн өсөлт, хувь хүний ёс зүй зэрэг нь авлигын нөхцөлдүүлэгч хэвээр байгаа бол шийдвэрлэх арга зам нь цалин орлогыг нэмэгдүүлэх, ил тод байдал-мэдээллээр хангах, авлига, ашиг сонирхол, шударга байдлын мэдлэг мэдээллээр хангах, хяналтыг сайжруулах зэрэг байна.

2025 оны энэхүү судалгааны тайлангийн эхний бүлэгт судалгааны аргазүй, хамрах хүрээг танилцуулсан. Хоёрдугаар бүлэгт, ГШБҮ-ний өнөөгийн нөхцөл хандлага, түүний бүрэлдэхүүн индекс ба дэд үзүүлэлтүүдийг байгууллагын төрлүүдээр дүгнэж тайлагнав.

Тайлангийн сүүлийн бүлэгт төрийн үйлчилгээ авч буй иргэдээс Монгол Улсын хэмжээнд авлигын өнөөгийн нөхцөл, ирээдүйн хандлагын талаарх асуултын үр дүнг харуулсан болно. Тухайн тайланг хэрэглэгчид нь үндсэн бүлгүүд дээрх дүгнэлтээс гадна хавсралтаар оруулсан байгууллага тус бүрээрх болон дэд үзүүлэлт, нэгж асуулт бүрээрх дэлгэрэнгүй мэдээллийг ашиглан дүгнэлт хийж, шийдвэр гаргавал зохино.


БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

1.1 Шударга байдлын үнэлгээний аргачлал

1.1.1 Үнэлгээний загвар

Шударга байдлын үнэлгээний судалгааг АТГ-ын даргын 2015 оны 12 сарын 10-ны өдрийн А/129 тушаалын I хавсралтаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэхүү аргачлалын дагуу шударга байдлын үнэлгээ нь дараах загвараар тодорхойлогддог (Схем 1).

СХЕМ 1. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ЗАГВАР



Эх үүсвэр: Шударга байдлын үнэлгээний аргачлал, АТГ, 2015

Шударга байдлын үнэлгээ нь гадаад шударга байдал, дотоод шударга байдал болон бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг бөгөөд гадаад шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагаар үйлчлүүлэн үйлчилгээ авсан иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын өгч буй үнэлгээгээр тодорхойлогддог.

1.1.2 Үнэлгээний утга

Шударга байдлын үнэлгээ нь 0-100 хүртэлх оноогоор үнэлэгдэнэ (шударга байдал~100 бол хамгийн шударга байдлыг илэрхийлнэ).

Гадаад шударга байдлыг дараах аргачлалын дагуу үнэлэв.

$$E_i = (A_i + B_i + C_i) / 3$$

E_i - i -р байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

A_i - авлигын индексийн оноо

B_i - ил тод байдлын индексийн оноо

C_i - хариуцлагатай байдлын оноо

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулахдаа дараах 2 аргын ашиглалаа. Үүнд:

- **Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсвэл**
- **Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах**

Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулахдаа 1-5 хүртэл хэмжээс бүхий Лайкертын хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэх ба дараах загварыг баримтална. Хэрвээ тухайн хариулт эерэг утгатай бол 100, сөрөг утгатай бол 0 оноог өгнө.

ХҮСНЭГТ 1. 1-5 ХҮРТЭЛ ХЭМЖЭЭС БҮХИЙ ХАРИУЛТЫГ ШБҮ-НИЙ 0-100 ОНООНД ШИЛЖҮҮЛЭХ

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100
Түгээмэл	2	25 эсвэл 75
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25
Огт байхгүй	5	100 эсвэл 0

Үзүүлэлтийн дундаж оноог тооцохдоо тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцно. Дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$\text{Үзүүлэлтийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах: Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийг оноожуулах: Байгууллага бүрийн давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийг оноожуулахдаа тухайн хариултын интервалыг нэг үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай ба дараах байдлаар шилжүүлнэ.

ХҮСНЭГТ 2. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ХУВЬД ДАВТАМЖ, ҮНИЙН ДҮНГ ОНООЖУУЛАХ

Хариулт	Давтамж	Шилжүүлэх оноо
Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх (шууд болон шууд бус байдлаар бэлэг өгөх) хандив, бусад санхүүгийн туслалцаа өгөх байдлыг оноожуулах	1 удаа	1
	2 удаа	2
	3 удаа	3
	4 – 5 удаа	4.5
	6-7 удаа	6.5
	8-9 удаа	8.5
	10-аас дээш удаа	10
Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх (шууд болон шууд бус байдлаар бэлэг өгөх) хандив, бусад санхүүгийн туслалцаа өгөх байдлыг үнийн дүнг оноожуулах	20000 ₮	20
	21000-50000₮	35.5
	51000-100000₮	77.5
	101000-300000₮	205
	301000-500000	405

501000-1000000₮	755
1.1 сая-2 сая ₮	1550
2.1-5 сая ₮	3550
5.1-10 сая ₮	7550
10.1 сая ₮-өөс дээш	10100

Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийн дунджийг тооцох: Тухайн байгууллагын давтамж (үнийн дүн)-ийн онооны нийлбэрт үндэслэн тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан нэг хүнд ногдох давтамж (үнийн дүн)-ийн онооны дунджийг дараах томъёогоор тооцно.

$$\text{Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийн дундаж} = \frac{\text{Тухайн байгууллагын давтамж (үнийн дүн) – ийн онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийг оноожуулах: Давтамж, үнийн дүнгийн дунджид үндэслэн бусад байгууллагатай жиших замаар байгууллагын давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийг оноожуулах бөгөөд дараах томъёогоор тооцно.


$$\text{Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн оноо} = 100 * \left(1 - \frac{\text{тухайн байгууллагын давтамж (үнийн дүн) – ийн дундаж}}{UCP}\right)$$

UCP нь бүх байгууллагын давтамж (үнийн дүн)-ийн дунджаас тооцсон өсөн нэмэгдэх гамма тархалтын 95%-тай тэнцүү утга буюу тухайн жилд хамгийн өндөр давтамж (үнийн дүн) бүхий байгууллагын дундаж

1.2 Судалгааны хамрах хүрээ

“Төрийн байгууллагуудын бодлогод оролцогчид, шинжээчдээс шударга байдлын үнэлгээ”-ний судалгаанд 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, Нийслэл, дүүргийн ЗДТГ-10 нийт 81 байгууллагын 10840 иргэд, аж ахуй нэгжийн төлөөллөөс судалгааны тоон мэдээллийг цуглууллаа. Түүврийн хэмжээг дараах схемээр харуулав.

Схем 2. Түүврийн хамрах хүрээ, түүврийн хэмжээ




Үүнд: Яамдаар үйлчлүүлж байгаа 1840 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаар үйлчлүүлж байгаа 3720 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, аймаг болон нийслэлийн ЗДТГ-аар үйлчлүүлж байгаа 3750 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, дүүргийн ЗДТГ-аар үйлчлүүлж байгаа 1530 иргэд, аж ахуй нэгжийн төлөөллийг тус бүр судалгаанд хамруулсан (Түүврийн дэлгэрэнгүйг Хавсралт 2-с харна уу)

1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 05 сарын 20-оос 2025 оны 07 сарын 20-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 25 хүн ажилласан.

Судалгааны багийн гишүүн нь судалгаа хэрхэн авах талаарх аргазүйн сургалтад хамрагдаж, мэдээлэл цуглуулах ажлыг талбар дээр нь гүйцэтгэн ажилласан болно. Мөн бид судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үйл явцыг тухайн төрийн байгууллагаар одоо цаг үед үйлчлүүлж буй иргэд, ААН болон өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН, тухайн байгууллагын бодлого боловсруулах үйл явцад оролцсон шинжээчидтэй холбогдон мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэлээ. Асуулгын хуудсыг онлайн хэлбэрт шилжүүлэн, тухайн байгууллагын вэбсайт болон тухайн байгууллагын ЭБАТ-аас өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН-ийн холбогдох утасны дугаар, мэйл хаяг зэрэг мэдээллийг авч холбогдох зэрэг аргуудыг ашиглалаа.

Схем 3. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт



БҮЛЭГ 2. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Гадаад шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөллийг хамруулдаг. 2025 онд 10840 иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллийг тус үнэлгээний судалгаанд хамруулсан байна. ГШБҮ-д 16 яам, 34 агентлаг, 22 аймаг, нийслэлийн ЗДТГ, 9 дүүргийн ЗДТГ-ийг хамруулж буй бөгөөд эдгээр байгууллагын тооноос хамаарч ямар төрлийн байгууллагад нийт хэдэн төлөөлөл үнэлгээ өгч байгааг дараах хүснэгтэд харууллаа. Нийт төлөөллийн 89.6 хувь нь иргэд, хувь хүн байсан бол, 10.4 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл байлаа. Судалгаанд оролцогчдын хүйсийн хувьд 53.9% нь эмэгтэй төлөөлөл байв.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Үнэлж буй байгууллагын төрлөөр	Яам	1840	17.0%
	Агентлаг	3720	34.3%
	Аймаг, нийслэлийн ЗДТГ	3750	34.6%
	Дүүргийн ЗДТГ	1530	14.1%
Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ хэнийг төлөөлсөн бэ?	Хувь хүн	9712	89.6%
	Аж ахуйн нэгж, байгууллага	1128	10.4%
Судалгаанд оролцогчдын нас	20 хүртэл	340	3.1%
	20-29	1802	16.6%
	30-39	3360	31%
	40-49	3026	27.9%
	50-59	1559	14.4%
	60-аас дээш	753	6.9%
Судалгаанд оролцогчдын хүйс	Эрэгтэй	4998	46.1%
	Эмэгтэй	5842	53.9%
Нийт		10840	

2.2 ГШБҮ-ний ерөнхий үр дүн

Төрийн байгууллагуудын ГШБҮ нь “авлигын эрсдэлийн индекс” ба “авлигын индекс” гэсэн хоёр дэд индекс, түүнд хамаарах 5 дэд үзүүлэлт, 20 нэгж үзүүлэлтүүдийн дунджаар тооцогддог. 2025 оны судалгаагаар төрийн байгууллагуудын гадаад шударга байдлын дундаж үнэлгээ нь 70.7 ба өмнөх онтой харьцуулахад 1.6 оноогоор өссөн байна. ГШБҮ-г бүрдүүлэгч *авлигын эрсдэлийн индекс* болон *авлигын индекс* нь энэ онд харгалзан 63.4 ба 77.9 оноогоор үнэлэгджээ. Энэ нь өмнөх оноос харгалзан 2.1 ба 1.2 оноогоор тус тус өссөн нь ГШБҮ-ний дундаж үнэлгээний өсөлтөд нөлөөлжээ¹.

¹2.3 ба 2.4 дэд бүлгүүдэд энэхүү 2 индексэд хамаарах 5 бүлэг үзүүлэлтийн үнэлгээний үр дүн, түүнд үзүүлсэн нэгж үзүүлэлтийн нөлөөллийг дэлгэрэнгүй тайлбарласан.

ЗУРАГ 1. ГШБҮ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2025 ОН



2025 онд агентлагуудын ГШБҮ хамгийн өндрөөр буюу 76 оноогоор үнэлэгджээ. Энэ нь өмнөх оноос 4.5 оноогоор өссөн үзүүлэлт юм. Харин яамдын үнэлгээ өмнөх оноос 3.2 оноогоор буурч энэ онд 68.6 гэсэн үнэлгээтэй байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд үнэлгээ нь өмнөх оноос 0.9 оноогоор буурсан үр дүнтэй. Дэд индексийн бүрэлдэхүүнүүдээр харвал, авлигын эрсдэлийн индекс нь авлигын индекстэй харьцуулахад бага үнэлгээтэй байгаа нь өмнөх жилүүдтэй адил байна.

Дээрх хоёр дэд индексийн тооцоололд ашигласан 5 дэд үзүүлэлт бүрийн энэ оны үнэлгээг төрийн байгууллагын ангиллаар дараах хүснэгтэд тоймлов. Хүснэгтээс нийтлэг ажиглагдаж буй зүйл нь, 3 төрлийн байгууллагын хувьд “ил тод байдал” хамгийн бага үнэлгээтэй байгаа бол “авлигын шууд тохиолдол” ба “авлигын шууд бус тохиолдол”-ын үнэлгээ бусад 3 дэд үзүүлэлтээсээ харьцангуй өндөр байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас үйлчилгээ авч буй иргэд, ААНБ-ууд нь төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангалтгүй гэж үнэлсэн ба цаашлаад албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх явдлыг мөн доогуур түвшинд үнэлж байна.


Хүснэгт 4. ГШБҮ-ний дэд үзүүлэлтүүд, төрийн байгууллагуудын төрлөөр, 2025 он

Төрийн байгууллагын төрөл	Авлигын эрсдэлийн		Авлигын индекс		
	Ил тод байдал	Хариуцлага тай байдал	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол
Ерөнхий дундаж	59.7	67.0	65.6	83.9	84.3
Яамд	58.3	64.5	63.1	79.6	84.8
Агентлаг	64.0	72.1	71.0	90.9	90.0
Аймаг, нийслэлийн ЗДТГ	54.0	61.1	58.9	76.3	75.2

Тайлбар: Онооны дүнг багаас их рүү нь улаанаас, ногоон өнгөөр тэмдэглэсэн байна.

Жил бүрийн ГШБҮ-ний судалгааны үр дүнг байгууллагын төрлөөр Зураг 2-т харьцуулан харуулав.

Зураг 2. ГШБҮ, байгууллагын төрлөөр, оноор



Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл ерөнхий ГШБҮ 70 оноотой, яамдынх 71.1, агентлагууд 72.6 оноотой байгаа бол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээ 65 оноотой тус тус байна. Үнэлгээний өөрчлөлтийн хувьд яамдын болон аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ сүүлийн 2 жилийн судалгаагаар дараалан буурсан байна. Агентлагуудын үнэлгээ жилүүдэд өсөлт, бууралт харилцан адилгүй бөгөөд энэ онд өсөлт үзүүлсэн байгууллагын бүлэг байлаа.

Энэ онд ГШБҮ-ний судалгаанд хамрагдсан 72 байгууллагаас 40 байгууллагын үнэлгээ нь ерөнхий дундаж болох 71.4 онооноос дээгүүр үнэлэгдсэн байна. Судалгаанд хамрагдсан байгууллагуудыг эрэмбэлэн харвал Оюуны өмчийн газар өмнөх оноос 1 байр урагшилж энэ онд тэргүүлсэн бол удаах дөрвөн эрэмбэд орсон байгууллагуудын үнэлгээ их дүнгээр өсөж, олон эрэмбээр урагшилсан байна. Хүснэгт 5). Тухайлбал, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Монополын эсрэг газар² зэрэг байгууллагуудын хувьд ГШБҮ-ний 5 дэд үзүүлэлт бүгдээрээ өмнөх оноос өссөн дүнтэй байна. Харин Архивын ерөнхий газрын хувьд “Ил тод байдал” ба “Хариуцлагатай байдал”-ын үзүүлэлтүүд өндөр өсөлттэй байсан нь 5 дугаар эрэмбэд ороход нөлөөлсөн байна.

Эрэмбийн сүүлийн 5 байгууллагаас Ховд, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудын ЗДТГ болон Боловсролын яамны үнэлгээ ихээр буурч, олон эрэмбээр ухарсан байна. Эдгээр дөрвөн байгууллагын ГШБҮ-ний бүх дэд үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан байна. Дорнод аймгийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ-ний онооны өөрчлөлт бага улмаар өмнөх оны эрэмбээс нэг дээшилсэн байна. Хавсралт 3-с судалгаанд хамрагдсан бүх байгууллагын дэд үзүүлэлтийн оноо болон индексийн оноо, тэдгээрийн өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийн дэлгэрэнгүйг харна уу.

Хүснэгт 5. ГШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

² Хуучнаар “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар”

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Оюуны өмчийн газар	2	1	88.6	90.2	1.6
2	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	41	2	68.5	89.2	20.7
3	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	32	3	71.3	87.4	16.1
4	Монополын эсрэг газар	29	4	72.0	86.6	14.6
5	Архивын ерөнхий газар	20	5	76.2	86.2	10.0
Хамгийн бага үнэлгээтэй:						
68	Боловсролын яам	55	68	61.4	52.4	-9
69	Ховд аймгийн ЗДТГ	50	69	65	51.6	-13.4
70	Дорнод аймгийн ЗДТГ	71	70	50.2	49.2	-1
71	Өвөрхангай аймгийн ЗДТГ	35	71	70.8	49.1	-21.7
72	Сүхбаатар аймгийн ЗДТГ	57	72	60.4	47.8	-12.6

Өмнөх оны үр дүнтэй харьцуулахад хамгийн их эерэг ба сөрөг өөрчлөлттэй 10 байгууллагын мэдээллийг дараах зурагт харууллаа.

Зураг 3. ГШБҮ хамгийн их өөрчлөлттэй байгууллагууд, өөрчлөлт, оноогоор



Энэ онд хамгийн өндөр өсөлттэй 5 байгууллагын ГШБҮ нь 20 ба түүнээс дээш оноогоор нэмэгдсэн байгаа бол хамгийн их бууралттай байгууллагуудын өөрчлөлт 15 ба түүнээс дээш оноогоор тус тус буурсан байна. Үндэсний геологийн алба өмнөх жилд нийт 72 байгууллагаас хамгийн доод эрэмбэд бичигдэж, 48.4 оноотой үнэлэгдсэн бол энэ онд ГШБҮ нь хамгийн их өсөлттэй буюу 28.7 оноогоор өсөж 22 дугаар эрэмбэд орсон байна. Энэхүү үнэлгээний өсөлтөд ил тод байдал (26.6↑), хариуцлагатай байдал (22.3↑), авлигын шууд тохиолдол (41↑), авлигын шууд бус тохиолдол (38↑)-ын өсөлтүүд чухал нөлөө үзүүлсэн байна. Цаашлаад Онцгой байдлын ерөнхий газар 62-оос 8 дүгээр эрэмбэд, Боловсролын ерөнхий газар 61-ээс 9 дугаар эрэмбэд, Увс аймгийн ЗДТГ 63-аас 18 дугаар эрэмбэд тус тус хүрч дээшилсэн байна. Өмнөх хүснэгтэд дурдсан Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар мөн хамгийн өндөр өсөлттэй 5 байгууллагад багтсан байна.

Харин хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгууллагад Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар хамаарч буй бөгөөд ил тод байдал (49.3↓), хариуцлагатай байдал (23.2↓), авлигын талаарх төсөөлөл (31.5↓) зэрэг үзүүлэлтүүдийн бууралт хамгийн их нөлөө үзүүлжээ. Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын ГШБҮ 21.7 оноогоор буурч эрэмбийн сүүлч хэсэгт хамаарахад нь авлигын шууд бус тохиолдол (27↓), авлигын талаарх төсөөлөл (23.8↓), хариуцлагатай байдал (22.6↓)-д гарсан бууралтууд их нөлөөлсөн байна.

Төрийн байгууллагуудын дунджаар ГШБҮ-ний нэгж асуултуудаас ил тод байдлын асуултууд (A1, A2), хариуцлагатай байдлын асуултууд (A3, A4), авлигын талаарх төсөөлөл (A5 – A10)-ийн асуултууд 58.9 – 69.0-ийн хооронд үнэлгээтэй буюу доогуур үнэлэгдэж байна. Авлигын шууд ба шууд бус тохиолдлын асуултууд харьцангуй өндөр буюу 69.9 – 95.6-ийн хооронд үнэлгээтэй байна. Эдгээрээс үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдал (60.6) , төсөв, санхүү, худалдан авалтын ил тод байдал (58.9), үйлчилгээ үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал (61.8), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (62.8) гэсэн асуултууд хамгийн бага үнэлгээтэй байна (Хавсралт 4). Энэ үр дүн өмнөх жилд мөн адил байжээ.

2.2.1 Яамдын ГШБҮ

2025 оны ГШБҮ-ний судалгаанд төрийн 16 яамаар үйлчлүүлж буй 1840 иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл хамрагдсан. Яамдын ГШБҮ-ний дундаж 68.6 байгаа нь төрийн байгууллагуудын дунджаас (ГШБҮ=70.7) 2.1 оноогоор бага, 2024 оны яамдын дундажтай харьцуулахад 3.2 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Энэ онд яамдын ГШБҮ нь 52.4 – 87.4 онооны хооронд хэлбэлзэж, 5 яамны үнэлгээ өсөж, 10 яамны үнэлгээ буурч, нэг яамны ГШБҮ-д өөрчлөлт ороогүй байна. Түүнчлэн 8 яамны үнэлгээ нь төрийн байгууллагуудын дундаж буюу 70.7-өөс өндөр байна.

Яамдын дунджаар авч үзэхэд ГШБҮ-г тооцоход ашигладаг 5 дэд үзүүлэлтүүд бүгд бууралттай, үүнээс ил тод байдал (4.0↓), авлигын шууд бус тохиолдол (2.7↓)-ын дундаж оноонууд хамгийн их нөлөөтэй байв (Хавсралт 3).

Яамдаас Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үнэлгээ 16.1 оноогоор өсөж 1 дүгээр эрэмбэд орсон байна. Үүнд нөлөөлсөн дэд үзүүлэлтүүдээс онцолбол, ил тод байдал (18.6↑), хариуцлагатай байдал (17.4↑), авлигын шууд тохиолдол (16.1↑) зэрэг үзүүлэлтүүдийн өсөлт байна. Өмнөх онд яамдаас хамгийн бага оноотой байсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны³ үнэлгээ мөн ихээр (15.7↑) өссөн байна. Тус яамны хувьд хариуцлагатай байдал (23.5↑), авлигын талаарх төсөөлөл (18.4↑), ил тод байдал (16.3↑) зэрэг үзүүлэлтүүдийн өсөлт хамгийн өндөр байна.

Боловсролын яам хамгийн бага буюу 52.4 оноотой, тус байгууллагын авлигын шууд тохиолдол (28.5↓), ил тод байдал (10.5↓) зэрэг үзүүлэлтүүд хамгийн их бууралттай. ГШБҮ хамгийн ихээр буурсан яам нь Эрчим хүчний яам (19.0↓) байна. Хамгийн их нөлөөтэй өөрчлөлт нь авлигын шууд бус тохиолдол (31.8↓), авлигын шууд тохиолдол (19.0↓), ил тод байдал (18.6↓), хариуцлагатай байдал (14.3↓) тус тус байна.

Хүснэгт 6. Яамдын ГШБҮ-ний үр дүн, 2024, 2025 онуудыг харьцуулсан үр дүн (2025 оны эрэмбээр)

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ	Өөрчлөлт
Яамдын ГШБҮ-ний дундаж			71.8	68.6	-3.2
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	10	71.3	87.4	16.1
2	Батлан хамгаалах яам	9	72.7	81.4	8.7
3	Эдийн засаг, хөгжлийн яам	6	78.1	78.2	0.1
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	1	83.0	76.1	-6.9
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	8	77.8	76.0	-1.8
6	Гадаад харилцааны яам	3	80.3	72.8	-7.5
7	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	4	78.6	71.7	-6.9
8	Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам	7	77.9	71.6	-6.3
9	Сангийн яам	15	60.3	69.2	8.9
10	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	16	52.2	67.9	15.7
11	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2	80.8	64.0	-16.8
12	Зам, тээврийн яам	13	62.4	63.7	1.3
13	Эрчим хүчний яам	5	78.6	59.6	-19.0
14	Эрүүл мэндийн яам	11	67.8	53.1	-14.7
15	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	12	61.4	52.6	-8.8
16	Боловсролын яам	14	66.2	52.4	-13.8

³ Хуучин нэршлээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

2.2.2 Агентлагуудын ГШБҮ

2025 оны агентлагуудын ГШБҮ-нд Засгийн газрын 34 хэрэгжүүлэгч агентлагаар үйлчлүүлсэн 3720 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл судалгаанд хамрагдсан. Агентлагуудын ГШБҮ-ний дундаж 76.0 байгаа нь улсын дунджаас 5.3 оноогоор өндөр үнэлэгдсэн бол өмнөх оны агентлагуудын дундаж үнэлгээтэй харьцуулахад 4.5 оноогоор өсжээ. Агентлагуудын ГШБҮ нь 59.9 – 90.3-ийн хооронд хэлбэлзэж байна. Энэ жил 22 агентлагийн үнэлгээ өссөн бол 12 байгууллагынх буурсан байна.

Агентлагуудын дунджаар авч үзэхэд ГШБҮ-г тооцоход ашигладаг 5 дэд үзүүлэлтүүд бүгд өсөлттэй, үүнээс хариуцлагатай байдал (6.3↑), авлигын талаарх төсөөллийн (6.1↑) дундаж оноонууд хамгийн их нөлөөтэй байв (Хавсралт 3).

Агентлагуудын ГШБҮ-г Оюуны өмчийн газар өмнөх оны эрэмбээс нэг шат өгсөж энэ онд тэргүүлж байгаа бол хамгийн өндөр өсөлттэй агентлаг нь Үндэсний геологийн алба (28.7↑) байна. Тус алба нь өмнөх онд агентлагуудын хамгийн сүүлийн байрт бичигдэж байсан бол энэ онд бүх үзүүлэлтүүд өндөр өсөлттэй, үүнээс авлигын шууд тохиолдол (38.5↑), авлигын шууд бус тохиолдол (38.0↑) -ын өөрчлөлт хамгийн их нөлөөлж, энэ оны эрэмбийн 15 дугаар байранд жагссан байна.

Энэ онд Ашигт малтмал, газрын тосны газар өмнөх оноос үнэлгээгээ ахиулсан ч (4.9↑), өмнөх оноос 1 байр ухарч энэ оны жагсаалтын сүүлд орсон байна. Хамгийн их бууралттай агентлаг нь “Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар” бөгөөд дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг өмнө

Зураг 3-т илэрхийлэн тайлбарласан. Удаах хамгийн их бууралттай нь Жижиг дунд, үйлдвэрийн газар бөгөөд авлигын шууд бус тохиолдол (28.9↓), авлигын талаарх төсөөлөл (22.5↓) үзүүлэлтүүд том нөлөөтэй байна.

Хүснэгт 7. Агентлагуудын ГШБҮ-ний үр дүн, 2024, 2025 онуудыг харьцуулсан үр дүн (2025 оны эрэмбээр)

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ	Өөрчлөлт
Агентлагуудын ГШБҮ-ний дундаж			71.5	76.0	4.5
1	Оюуны өмчийн газар	2	88.6	90.3	1.7
2	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	25	68.5	89.2	20.7
3	Монополын эсрэг газар	17	72.0	86.6	14.6
4	Архивын ерөнхий газар	9	76.2	86.2	10.0
5	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	10	75.5	84.8	9.3
6	Нийгмийн даатгалын ерөнхий газар	20	71.1	84.6	13.4
7	Онцгой байдлын ерөнхий газар	32	59.0	83.7	24.8
8	Боловсролын ерөнхий газар	31	59.6	83.7	24.1
9	Цаг уур, орчны шинжилгээний газар	22	70.5	83.1	12.6
10	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	24	69.2	82.8	13.6
11	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	13	73.6	80.1	6.5
12	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	19	71.2	79.1	7.9
13	Ойн газар	15	73.0	78.2	5.2
14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	12	73.7	77.7	4.0

15	Үндэсний геологийн алба	34	48.4	77.1	28.7
16	Стандарт, хэмжил зүйн газар	16	72.9	76.0	3.1
17	Татварын ерөнхий газар	30	60.4	75.2	14.9
18	Төрийн худалдан авах ажиллагааны газар	28	67.7	74.9	7.2
19	Цагдаагийн ерөнхий газар	29	67.2	74.8	7.6
20	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	6	78.4	74.7	-3.8
21	Гадаадын иргэн харьяатын газар	7	77.9	74.3	-3.6
22	Усны газар	5	79.6	74.1	-5.4
23	Биеийн тамир, спортын улсын хороо	3	80.5	72.9	-7.5
24	Гаалийн ерөнхий газар	26	68.4	71.2	2.8
25	Шүүх шинжилгээний ерөнхий газар	21	70.6	71.1	0.5
26	Иргэний нисэхийн ерөнхий газар	18	71.3	70.6	-0.8
27	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	8	76.5	69.9	-6.6
28	Улсын бүртгэлийн ерөнхий газар	11	74.7	69.4	-5.3
29	Мал эмнэлгийн ерөнхий газар	23	69.4	68.9	-0.5
30	Жижиг, дунд үйлдвэрийн газар	4	80.3	67.7	-12.6
31	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	27	68.3	67.0	-1.2
32	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газар	1	90.1	63.4	-26.8
33	Соёл урлагийн газар	14	73.1	61.1	-12.1
34	Ашигт малтмал, газрын тосны газар	33	55.0	59.9	4.9

2.2.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ

Энэ оны судалгаанд өмнөх онтой адил 21 аймгийн болон нийслэлийн ЗДТГ-аар үйлчлүүлсэн 3930 иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл судалгаанд хамрагдсан. Аймаг болон нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ-ний дундаж нь 63.9 байгаа нь улсын дунджаас 6.8 оноогоор доогуур, 2024 оны аймаг болон нийслэлийн дундаж ГШБҮ-тэй харьцуулахад 0.3 оноогоор буурсан байна.

Эдгээр ЗДТГ-уудын ГШБҮ-ний өөрчлөлтөд авлигын шууд тохиолдол (2.3↓), авлигын шууд бус тохиолдлын (1.8↓) үнэлгээний өөрчлөлтүүд их нөлөөтэй байлаа (Хавсралт 3).

Энэ онд аймаг болон нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ-н Нийслэлийн ЗДТГ тэргүүлж байна. Тус байгууллагын үнэлгээний өсөлтөд ил тод байдал (28.0↑), хариуцлагатай байдал (18.0↑), авлигын шууд тохиолдол (12.1↑) үзүүлэлтүүд өндөр нөлөөтэй байна. Увс аймгийн ЗДТГ-ын ГШБҮ нь хамгийн өндөр өсөлттэй байсан. Тус байгууллагын хувьд авлигын индексэд хамаарах 3 дэд үзүүлэлтүүд буюу авлигын талаарх төсөөлөл (20.4↑), авлигын шууд тохиолдол (20.7↑), авлигын шууд бус тохиолдол (38.9↑) зэрэг нь өндөр үнэлгээ авсан байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын авлигын шууд бус тохиолдол (31.0↓), авлигын шууд тохиолдол (13.7↓), ил тод байдлын (12.0↓) үзүүлэлтийн бууралтууд тухайн байгууллагыг эрэмбийн сүүлд ороход нөлөөлсөн. Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн их бууралттай (21.7↓) байна. Авлигын шууд бус тохиолдол (27.0↓), авлигын шууд тохиолдол (21.0↓), авлигын талаарх төсөөлөл (23.8↓), хариуцлагатай байдал (22.6↓)-ын үзүүлэлтүүд их буурсан нь үүнд нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Аймаг болон нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ-ний үр дүн, 2024 болон 2025 оныг харьцуулсан үр дүн (2025 оны эрэмбээр)

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ	Өөрчлөлт
Аймаг болон нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ-ний дундаж			64.1	63.8	-0.3
1	Нийслэлийн ЗДТГ	12	64.4	80.4	16.0
2	Төв аймгийн ЗДТГ	1	81.6	79.0	-2.6
3	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	2	80.4	78.7	-1.8
4	Увс аймгийн ЗДТГ	16	58.3	78.2	19.9
5	Дундговь аймгийн ЗДТГ	7	66.2	76.3	10.1
6	Хэнтий аймгийн ЗДТГ	4	71.5	73.8	2.3
7	Өмнөговь аймгийн ЗДТГ	15	60.3	69.0	8.7
8	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	18	56.9	68.2	11.4
9	Хөвсгөл аймгийн ЗДТГ	20	55.3	66.6	11.3
10	Булган аймгийн ЗДТГ	11	64.6	65.7	1.1
11	Говь-Алтай аймгийн ЗДТГ	3	77.6	63.6	-14.0
12	Завхан аймгийн ЗДТГ	10	64.7	62.6	-2.1
13	Архангай аймгийн ЗДТГ	13	60.5	60.4	-0.1
14	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	19	56.1	60.1	3.9
15	Орхон аймгийн ЗДТГ	17	57.9	59.5	1.6
16	Дорноговь аймгийн ЗДТГ	8	65.4	57.6	-7.7
17	Дархан-Уул аймгийн ЗДТГ	6	69.6	53.9	-15.8
18	Баянхонгор аймгийн ЗДТГ	21	53.1	53.4	0.2
19	Ховд аймгийн ЗДТГ	9	65	51.6	-13.4
20	Дорнод аймгийн ЗДТГ	22	50.2	49.2	-0.9
21	Өвөрхангай аймгийн ЗДТГ	5	70.8	49.2	-21.7
22	Сүхбаатар аймгийн ЗДТГ	14	60.4	47.8	-12.5


2.3. Авлигын эрсдэлийн индекс

Авлигын эрсдэлийн индекс нь ГШБҮ-г тооцоход ашигладаг эхний үзүүлэлт бөгөөд түүнийг байгууллагын **ил тод байдал** болон **хариуцлагатай байдлын** үзүүлэлтүүдийн дунджаар тооцдог. Одоогийн үнэлгээний аргачлалын дагуу төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал ба хариуцлагатай байдлын талаарх 4 нэгж асуултаар авлигын эрсдэлт байдлыг үнэлж байна. Үнэлгээний нэгж асуултуудыг Хавсралт 1-ээс харна уу.

2025 оны авлигын эрсдэлийн индекс 63.4 оноогоор үнэлэгдсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 2.1 оноогоор илүү байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл нь төрийн байгууллагуудын ил тод байдлыг дунджаар 59.7, хариуцлагатай байдлыг 67.0 оноогоор тус тус үнэлсэн ба өмнөх оноос харгалзан 1.2 ба 2.9 оноогоор өссөн үр дүн юм. Авлигын эрсдэлийн индекс болон түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт сүүлийн 4 жилд харьцангуй өөрчлөлт багатай байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагуудын ил тод байдал ба хариуцлагатай байдлын талаарх олон нийтийн төсөөлөл төдийлөн өөрчлөлтгүй байна.


Хавсралт 5-д авлигын эрсдэлийн индексийн 4 нэгж асуултын дундаж үнэлгээ, түүний өөрчлөлтийг харууллаа. Энэ оны судалгаагаар ил тод байдал ба хариуцлагатай байдлын бүх асуултууд өмнөх оноос өссөн үнэлгээтэй байна.

Зураг 4. Авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтээр, сүүлийн 5 жилээр



Авлигын эрсдэлийн индекс ба түүний бүрэлдэхүүнийг байгууллагуудын төрлөөр авч үзвэл энэ онд агентлагуудын үнэлгээ бусад төрлийн байгууллагаас өндөр байна. Энэ нь 2024 онд яамдын авлигын эрсдэлийн индекс ба бүрэлдэхүүн үзүүлэлтүүд хамгийн өндөр байснаас ялгаатай үр дүнг үзүүлсэн байна. Харин өмнөх онтой адил аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээ хамгийн бага хэвээр байгаа нь ЗДТГ-уудын үйл ажиллагааны ил тод ба хариуцлагатай байдалд иргэд харьцангуй бага үнэлгээг өгсөөр байна.

Зураг 5. Авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2025



2.3.1 Яамдын авлигын эрсдэлийн индекс

Энэ онд нийт 16 яамны дунджаар авлигын эрсдэлийн индекс 2.7 оноогоор буурсан ба нийт яамдын дунджаар авч үзвэл 2 дэд үзүүлэлтүүд бүгд буурсан байна (Хүснэгт 9). Нийтдээ 7 яамны авлигын эрсдэлийн индекс нь төрийн байгууллагуудын дундаж индексээс (63.4) өндөр үр дүнтэй байна. Цаашлаад 4 яамны авлигын эрсдэлийн индексийн үнэлгээ өссөн бол 9 яамны үнэлгээ буурсан нь тус бүлэг байгууллагын авлигын эрсдэлийн индекс энэ онд агентлагуудын дундаж түвшнээс бага гарахад нөлөөлжээ.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам авлигын эрсдэлийн индексийн хамгийн өндөр үнэлгээг авсан ба үүнд тухайн байгууллагын үйл ажиллагаа-хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал (23.0↑), төсөв санхүү-худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал (14.2↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн ёс зүй (20.6↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлт (14.2↑)-ын талаарх асуултууд бүгд өссөн нь нөлөөтэй байна.

Хүснэгт 9. Яамдын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	82.6	18.6	17.4	18.0
2	Батлан хамгаалах яам	74.2	10.3	-0.8	4.7
3	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	73.5	1.6	-3.1	-0.8
4	Эдийн засаг хөгжлийн яам	70.3	1.5	-1.6	-0.1
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	67.2	-5.1	2.5	-1.3
6	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	64.9	16.3	23.5	19.9
7	Гадаад харилцааны яам	63.5	-10.5	-4.2	-7.3
8	Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам	61.7	-16.0	-6.8	-11.4
9	Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	59.8	-8.5	-8.3	-8.4
10	Сангийн яам	58.4	-9.0	7.2	-0.9
11	Зам, тээврийн яам	57.0	3.4	2.6	3.0
12	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	56.0	-16.2	-14.5	-15.3
13	Эрчим хүчний яам	54.5	-18.6	-14.3	-16.4
14	Эрүүл мэндийн яам	49.2	-13.4	-6.6	-10.0
15	Боловсролын яам	45.6	-10.5	-9.8	-10.2
16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	43.6	-8.3	-3.6	-5.9
	Яамдын дундаж	61.4	-4.0	-1.3	-2.7

Авлигын эрсдэлийн индексийн хамгийн их өсөлтийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үр дүн харуулжээ. Тус байгууллагын үйл ажиллагаа-хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал (13.3↑), төсөв санхүү-худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал (19.3↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн ёс зүй (17.2↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлт (29.7↑)-ын талаарх асуултууд өмнөх оноос өндрөөр үнэлэгдсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамгийн бага үнэлгээтэй ба индексэд хамаарах 4 асуулт бүгд өмнөх оноос бууралттай. Үүнээс төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал 12.5 оноогоор буурсан нь өмнөх оны дүнгээс доош буурахад хамгийн их нөлөөлсөн байна. Эрчим хүчний яамны авлигын эрсдэлийн индекс хамгийн их бууралтыг үзүүлжээ. Иргэдийн төлөөлөл тус яамны ил тод байдлын асуултуудад өмнөх оноос 18 оноогоор бага үнэлгээ өгч, төрийн үйлчилгээг үзүүлэх үеийн хүчин чармайлтыг (18.7↓) мөн доогуур үнэлсэн байна. Хавсралт 4-аас нэгж асуултуудын 2025 оны үнэлгээг, Хавсралт 6-аас нэгж асуултуудын өөрчлөлтийн утгыг байгууллага тус бүрээр харна уу.

2.3.2 Агентлагуудын авлигын эрсдэлийн индекс

Агентлагуудын дундаж авлигын эрсдэлийн индекс өмнөх оноос 5.5 оноогоор өсөж 68.1 үнэлгээтэй байна. Агентлагуудын тухайн индексийн өөрчлөлтийг харахад харьцангуй өндөр үнэлгээний өсөлттэй байгууллагын тоо олон байна. Авлигын эрсдэлийн индекс буурсан байгууллагууд дунд нэгээс бусад байгууллагын үнэлгээний бууралт нэг оронтой тооны хэмжээнд байгаа нь онцлог байна (Хүснэгт 10). Уг индексэд хамаарах нэгж асуултууд дундаас төрийн үйлчилгээг үзүүлэх үеийн хүчин чармайлт 7.6 онооны өсөлттэй, бусад гурван асуулт бүгд 4 оноо ба түүнээс дээш өсөлттэй байна (Хавсралт 6 – агентлагуудын дундаж мөр).

Хүснэгт 10. Агентлагуудын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	84.4	31.8	19.1	25.5
2	Оюуны өмчийн газар	84.0	2.3	0.7	1.5
3	Архивын ерөнхий газар	79.9	17.5	13.2	15.4
4	Монополын эсрэг газар	79.3	22.9	14.6	18.7
5	Боловсролын ерөнхий газар	78.4	24.2	24.2	24.2
6	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	76.8	13.3	7.1	10.2
7	Нийгмийн даатгалын ерөнхий газар	76.2	15.9	17.3	16.6
8	Онцгой байдлын ерөнхий газар	75.8	27.9	28.5	28.2
9	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	74.6	6.8	9.3	8.0
10	Цаг уур, орчны шинжилгээний газар	73.8	22.4	16.5	19.4
11	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	73.0	4.6	4.1	4.4
12	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	72.0	2.1	15.3	8.7
13	Стандарт, хэмжил зүйн газар	70.4	6.7	11.4	9.0
14	Ойн газар	70.0	7.7	2.4	5.0
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	69.9	-3.8	9.6	2.9
16	Үндэсний геологийн алба	68.8	26.6	22.3	24.5
17	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	68.8	3.1	7.0	5.0
18	Гадаадын иргэн харьяатын газар	68.0	-3.9	-1.7	-2.8

19	Цагдаагийн ерөнхий газар	66.4	6.2	13.4	9.8
20	Татварын ерөнхий газар	64.5	7.7	9.7	8.7
21	Биеийн тамир, спортын улсын хороо	64.5	-11.6	-5.8	-8.7
22	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	64.4	-11.3	0.5	-5.4
23	Гаалийн ерөнхий газар	63.8	-10.6	4.7	-3.0
24	Усны газар	63.8	-5.0	-4.7	-4.9
25	Төрийн худалдан авах ажиллагааны газар	63.2	6.6	12.6	9.6
26	Шүүх шинжилгээний ерөнхий газар	62.8	-0.5	-0.2	-0.4
27	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	62.8	11.7	-0.2	5.8
28	Жижиг, дунд үйлдвэрийн газар	62.1	5.6	-15.8	-5.1
29	Иргэний нисэхийн ерөнхий газар	60.8	-4.7	3.6	-0.5
30	Ашигт малтмал, газрын тосны газар	57.0	4.5	8.0	6.3
31	Улсын бүртгэлийн ерөнхий газар	56.5	-14.1	-3.7	-8.9
32	Соёл урлагийн газар	54.3	-0.8	-4.2	-2.5
33	Мал эмнэлгийн ерөнхий газар	54.0	-5.3	-0.7	-3.0
34	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий	48.8	-49.3	-23.2	-36.3
	Агентлагуудын дундаж	68.1	4.6	6.3	5.5

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын авлигын эрсдэлийн индекс 25.5 онооны өсөлттэйгөөр хамгийн эхний эрэмбэд орсон байна. Үүнд тус газрын үйл ажиллагаа-хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал (31.0↑), төсөв санхүү-худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал (33.0↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлт (28↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн ёс зүйн (10↑) талаарх асуултууд бүгд өссөн нь нөлөөтэй байна.

Энэ онд Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагаа-хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал (32↑), төсөв санхүү-худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал (24↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн ёс зүй (33↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлт (24↑)-ын талаарх асуултуудад иргэд өмнөх оноос харьцангуй өндөр үнэлгээ өгснөөр тус байгууллага авлигын эрсдэлийн индексийн өсөлт хамгийн их байна.

Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газрын авлигын эрсдэлийн индекс хамгийн их бууралттайгаар агентлагийн төрөлдөө энэ оны хамгийн бага үнэлгээг авсан байна. Тус байгууллагын судалгааг дүүргийн газрын албаар үйлчлүүлэгчдээс авсан ба энэ онд үйл ажиллагаа-хүний нөөцийн ил тод байдал 40 оноо, төсөв-санхүү, худалдан авалтын ил тод байдал 25 оноо, төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлт 58 оноотой үнэлэгдсэн байна.

Хавсралт 4-аас нэгж асуултуудын 2025 оны үнэлгээг, Хавсралт 6-аас нэгж асуултуудын өөрчлөлтийн утгыг байгууллага тус бүрээр харна уу.

2.3.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын эрсдэлийн индекс

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын дундаж авлигын эрсдэлийн индекс өмнөх оны түвшинд буюу 0.3 онооны өөрчлөлттэй байна. Хэдий тийм боловч, ЗДТГ тус бүрийн авлигын эрсдэлийн индексийн өөрчлөлт харилцан адилгүй байна. Энэ онд 8 ЗДТГ-ын авлигын эрсдэлийн индекс өмнөх оноос буурсан бол төдийлөн өөрчлөлтгүй 7 байгууллага байгаа нь өмнөх төрийн байгууллагын төрлүүдээс онцлог байна (Хүснэгт 11).

2025 оны судалгаагаар Нийслэлийн ЗДТГ-ын авлигын эрсдэлийн индекс хамгийн их өсөлттэйгөөр эхний эрэмбэд орсон байна. Үүнд тус газрын үйл ажиллагаа-хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал (22.0↑), төсөв санхүү-худалдан авах ажиллагааны

мэдээллийн ил тод байдал (34.0↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлт (23↑), төрийн үйлчилгээ үзүүлэх үеийн ёс зүйн (13↑) талаарх асуултууд бүгд өссөн нь нөлөөтэй байна.

Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Нийслэлийн ЗДТГ	72.9	28.0	18.0	23.0
2	Увс аймгийн ЗДТГ	71.7	10.9	15.4	13.1
3	Төв аймгийн ЗДТГ	71.2	4.7	-6.1	-0.7
4	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	71.2	1.4	-2.1	-0.4
5	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	71.0	6.2	15.9	11.1
6	Дундговь аймгийн ЗДТГ	66.7	11.2	6.4	8.8
7	Хэнтий аймгийн ЗДТГ	65.9	4.2	5.4	4.8
8	Өмнөговь аймгийн ЗДТГ	65.8	12.9	15.7	14.3
9	Булган аймгийн ЗДТГ	63.7	-1.3	1.3	0.0
10	Орхон аймгийн ЗДТГ	57.4	-3.1	1.3	-0.9
11	Говь-Алтай аймгийн ЗДТГ	56.6	-17.6	-11.3	-14.4
12	Завхан аймгийн ЗДТГ	55.9	3.5	-2.3	0.6
13	Хөвсгөл аймгийн ЗДТГ	55.6	-7.5	8.8	0.6
14	Дархан-Уул аймгийн ЗДТГ	54.5	-7.7	-7.0	-7.4
15	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	52.5	8.2	-1.3	3.5
16	Архангай аймгийн ЗДТГ	51.1	-4.9	0.6	-2.1
17	Баянхонгор аймгийн ЗДТГ	47.7	-8.7	6.2	-1.3
18	Дорноговь аймгийн ЗДТГ	47.2	4.4	-13.8	-4.7
19	Ховд аймгийн ЗДТГ	44.7	-13.3	-14.0	-13.7
20	Өвөрхангай аймгийн ЗДТГ	41.1	-16.1	-22.6	-19.4
21	Дорнод аймгийн ЗДТГ	41.0	-6.4	5.7	-0.3
22	Сүхбаатар аймгийн ЗДТГ	40.9	-12.0	-3.6	-7.8
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд	57.6	-0.15	0.76	0.31

Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээ хамгийн бага ЗДТГ нь Сүхбаатар аймгийнх бол үнэлгээ хамгийн ихээр буурсан нь Өвөрхангай аймгийнх байна. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ил тод байдлын дундаж оноо 40.9, хариуцлагатай байдлын дундаж оноо 48.3 буюу үйлчлүүлэгч иргэдийн төлөөллийн үнэлэмж маш хангалтгүй байна (Хавсралт 3). Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын хувьд иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл тус байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдал (29.1↓), төрийн үйлчилгээг үзүүлэх үеийн хүчин чармайлт (28.5↓), үйлчилгээ үзүүлэх үеийн ёс зүйн байдал (16.7↓)-ыг өмнөх оноос багаар үнэлжээ (Хавсралт 6).

Хавсралт 4-аас нэгж асуултуудын 2025 оны үнэлгээг, Хавсралт 6-аас нэгж асуултуудын өөрчлөлтийн утгыг байгууллага тус бүрээр харна уу.

2.4 Авлигын индекс


Авлигын индекс нь ГШБҮ-г тооцоход ашигладаг сүүлийн үзүүлэлт бөгөөд энэхүү үзүүлэлтийг тооцохдоо **авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол** гэсэн 3 дэд үзүүлэлтийг ашигладаг.

Авлигын индекс нь ГШБҮ-г тооцоход ашигладаг сүүлийн үзүүлэлт бөгөөд түүнийг байгууллагын **авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол** гэсэн 3 дэд үзүүлэлтүүдийн дунджаар тооцдог. Үнэлгээний хүрээнд дээрх дэд үзүүлэлтүүдэд хамаарах 20 асуулт судалгаанд орсон ч үүний 16 нь авлигын индексийн тооцоололд ашиглагдаж байна. Үлдсэн асуултуудаас 3 нь шалтгаан, нөхцөлийг тодруулсан чанарын асуулт бол нэг нь байгууллага дахь авлигын нөлөөг тодруулах, тооцоололд хамаарахгүй асуулт байна.

2025 оны авлигын индекс нь 77.9 оноотой үнэлэгдсэн нь 2024 оны үзүүлэлттэй харьцуулахад 1.2 оноогоор өссөн байна. Судалгаанд оролцогчид төрийн байгууллага дахь авлигын талаарх төсөөллийг 65.6 оноогоор үнэлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.3 оноогоор өссөн байна. Харин төрийн байгууллагууд дахь авлигын шууд ба шууд бус тохиолдлын талаарх туршлагын үзүүлэлтүүд харгалзан 83.9 ба 84.3 оноотой буюу өмнөх оноос -0.3 ба 0.8 онооны өөрчлөлттэй үнэлгээнд орж иржээ.


Ерөнхийдөө, судалгаанд оролцогчдод нэг талаас авлигын тохиолдлын тоо бага, нөгөө талаас байсан ч мэдээлэх хүсэлгүй зэргээс сүүлийн 2 дэд үзүүлэлт харьцангуй өндөр үнэлгээтэй байдаг бол авлигын талаарх төсөөллийн үнэлгээ жил бүр бусад үзүүлэлтүүдээс бага байна. Хавсралт 7-д авлигын индексийн 16 нэгж асуултын дундаж үнэлгээ, түүний өөрчлөлтийг харуулсан байна. Тухайн хавсралтаас нийт төрийн байгууллагуудын дунджаар нэгж асуултуудад ямар өөрчлөлт гарсныг харж болно.

Зураг 6. Авлигын индекс, дэд үзүүлэлтээр, сүүлийн 5 жилээр



Авлигын индексийг байгууллагын төрлөөр авч үзвэл, агентлагуудын авлигын индекс нь яам болон аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээнээс өндөр байгаа нь өмнөх жилтэй адил байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын индекс болон дэд үзүүлэлтүүд байгууллагын төрлүүд дундаа бага хэвээр байна. Энэхүү хандлага авлигын эрсдэлийн индекс дээр мөн адил байсан билээ.

Зураг 7. Авлигын индекс болон түүний дэд үзүүлэлтүүд, байгууллагын төрлөөр, 2025 он



2.4.1 Яамдын авлигын индекс

Яамдын дундаж авлигын индекс энэ онд 75.8 онооны үнэлгээгээр өмнөх оноос 3.8 оноогоор буурсан үр дүнтэй. Нийт яамдын дунджаар авч үзвэл 3 дэд үзүүлэлтүүд бүгд буурсан байна (Хүснэгт 12). Яам тус бүрийн авлигын индексийн өөрчлөлтүүд харилцан адилгүй бөгөөд 5 яамны авлигын индекс өсөлттэй, 9 яамных буурсан, нэг яам төдийлөн өөрчлөлтгүй байна. Дараах хүснэгтээс байгууллага тус бүр дэд үзүүлэлтээр хэрхэн өөрчлөгдсөнийг харах боломжтой бол индексэд хамаарах асуулт тус бүрийн оноо ба өөрчлөлтийг Хавсралт 4, Хавсралт 8, Хавсралт 9-аас харж болно.

Авлигын индексийн яамдын бүлэг доторх эрэмбэ нь өмнөх авлигын эрсдэлийн индекстэй нэлээд төстэй буюу ил тод байдал ба хариуцлагатай байдалд өндөр үнэлгээ авсан яамдын авлигын индексийн үнэлгээ мөн өндөр байх хандлага байна. Тухайлбал, авлигын индексийн оноогоор мөн л Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам тэргүүлж, Батлан хамгаалах яам удаалсан байна.

Эрэмбийн эхэнд орсон байгууллагын хувьд Хавсралт 8 ба Хавсралт 9-аас дүгнэхэд авлигын талаарх төсөөллийн бүх 6 асуултын үнэлгээ 12 ба түүнээс дээш оноогоор өссөн, өмнө жил авлигын шууд тохиолдлын тоо олон байсан бол энэ жил буурсан зэрэг нь ийнхүү үр дүн гарахад нөлөөлжээ.

Хүснэгт 12. Яамдын авлигын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он

№	Байгууллагын нэр	Авлигын индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	92.2	14.8	15.8	12.0	14.2
2	Батлан хамгаалах яам	88.7	2.3	24.0	12.0	12.8
3	Эдийн засаг хөгжлийн яам	86.2	1.7	1.9	-2.5	0.4
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	84.8	-0.8	-0.4	-5.5	-2.2
5	Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	83.5	-10.5	-8.0	1.9	-5.5

6	Гадаад харилцааны яам	82.1	-5.6	-9.0	-8.7	-7.8
7	Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам	81.5	-9.1	8.6	-2.8	-1.1
8	Сангийн яам	79.9	19.7	10.2	25.9	18.6
9	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	78.7	-8.9	-21.1	-9.1	-13.0
10	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	71.4	-15.8	-36.4	-4.2	-18.8
11	Зам, тээврийн яам	71.0	-0.4	6.2	-4.7	0.4
12	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	70.8	18.4	9.3	7.0	11.6
13	Эрчим хүчний яам	64.8	-13.5	-19.0	-31.8	-21.4
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	61.6	-6.2	-18.2	-39.3	-21.2
15	Боловсролын яам	59.1	-6.7	-28.5	11.5	-7.9
16	Эрүүл мэндийн яам	57.0	-2.0	-50.7	-5.5	-19.4
	Яамд	75.8	-1.4	-7.2	-2.7	-3.8

Авлигын индексээр хамгийн их өсөлттэй байгууллага нь Сангийн яам байна. Тус байгууллагын авлигын талаарх төсөөллийн 6 асуултаас 5 нь 19 ба түүнээс дээш оноогоор өссөн. Судалгаанд оролцогчдын хариултаар авлигын шууд ба шууд бус тохиолдлын тоо, давтамж мөн бага гарсан байна. Өмнөх жилд авлигын индексийн доод эрэмбэд байсан Сангийн яам, Аж үйлдвэрийн яамдын үнэлгээ энэ онд өндрөөр өссөн байна.

Авлигын индексийн яамдын эрэмбийн сүүлийн байгууллагууд нь өмнөх авлигын эрсдэлийн индекстэй мөн төстэй байна. Энэ удаа Эрүүл мэндийн яам хамгийн бага үнэлгээтэй бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ба Эрчим хүчний яамд хамгийн их бууралттай байна. Үүнээс Эрүүл мэндийн яамны хувьд авлигын төсөөллийн талаарх 6 асуулт бүгд 50-53 онооны хооронд үнэлэгдсэн, цаашлаад тухайн байгууллагын албан хаагчид бэлэг өгсөн тоо нийт төрийн байгууллага дунд хамгийн олон байснаас авлигын шууд тохиолдлын үзүүлэлт 33.4 оноогоор огцом буурсан зэрэг нь нөлөөлсөн байна. Хамгийн их бууралттай хоёр байгууллагын хувьд гол шалтгаанууд нь авлигын шууд бус тохиолдлын тоо өссөнтэй холбоотой байна (Хүснэгт 12).

Яамд нь авлигын индексийн асуулт тус бүрээр ямар үнэлгээтэй, ямар өөрчлөлттэй гүйцэтгэл үзүүлснийг Хавсралт 4, Хавсралт 8, Хавсралт 9-аас харан, энэ оны өөрчлөлтийн шалтгаанд дүгнэлт хийж болно.

2.4.2 Агентлагуудын авлигын индекс

Энэ оны судалгаагаар нийт агентлагуудын дундаж авлигын индекс 84 ба өмнөх оноос 3.5-аар өссөн байна. Нийт агентлагуудын дунджаар харвал 3 дэд үзүүлэлтүүд бүгд өсөлттэй гарчээ (Хүснэгт 13). Нийт 34 агентлагаас 9 байгууллагын авлигын индекс буурсан, 3 байгууллага төдийлөн өөрчлөлтгүй бол үлдсэн нь өмнөх оноос илүү үнэлгээ авсан байна. Мөн 26 агентлагийн авлигын индексийн үнэлгээ төрийн байгууллагуудын дундаж (77.9)-өөс өндөр байна. Дараах хүснэгтээс байгууллага тус бүр дэд үзүүлэлтээр хэрхэн өөрчлөгдсөнийг харах боломжтой бол индексэд хамаарах асуулт тус бүрийн оноо ба өөрчлөлтийг Хавсралт 4, Хавсралт 8, Хавсралт 9-аас харж болно.

Авлигын индексийн эрэмбээр агентлагууд дундаа Оюуны өмчийн газар тэргүүлсэн хэвээр байна. Харин өмнөх онд доогуур үнэлгээтэй байсан Үндэсний геологийн алба, Татварын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар,

Эм,эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрууд ⁴ энэ онд хамгийн өндөр өсөлттэй үр дүнг үзүүлсэн нь өмнөх жилийн ГШБҮ-ний үр дүнд анхаарч ажилласан гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 13. Агентлагуудын авлигын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он

№	Байгууллагын нэр	Авлигын индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Оюуны өмчийн газар	96.6	4.4	0.0	1.3	1.9
2	Монополын эсрэг газар	93.9	19.0	3.8	8.5	10.4
3	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	93.9	21.4	13.5	12.8	15.9
4	Нийгмийн даатгалын ерөнхий газар	93.0	18.9	4.8	7.0	10.2
5	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	92.8	10.3	3.1	12.0	8.4
6	Архивын ерөнхий газар	92.5	16.0	-1.1	-1.0	4.6
7	Цаг уур, орчны шинжилгээний газар	92.4	18.3	0.0	-1.1	5.7
8	Онцгой байдлын ерөнхий газар	91.6	39.3	15.9	8.8	21.3
9	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	90.9	15.1	24.5	17.6	19.1
10	Боловсролын ерөнхий газар	89.0	28.1	9.2	34.7	24.0
11	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	87.3	1.3	18.5	6.0	8.6
12	Төрийн худалдан авах ажиллагааны газар	86.6	13.4	-1.6	2.5	4.8
13	Ойн газар	86.4	10.9	-1.6	7.0	5.4
14	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	86.2	10.8	7.3	3.3	7.1
15	Татварын ерөнхий газар	86.0	17.0	16.0	30.2	21.1
16	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	85.6	4.6	18.6	-7.6	5.2
17	Үндэсний геологийн алба	85.4	22.7	38.5	38.0	33.0
18	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	84.9	-2.9	1.2	-4.6	-2.1
19	Усны газар	84.5	-2.3	-4.7	-10.9	-6.0
20	Мал эмнэлгийн ерөнхий газар	83.9	5.2	8.7	-7.7	2.0
21	Цагдаагийн ерөнхий газар	83.2	14.2	4.4	-2.7	5.3
22	Улсын бүртгэлийн ерөнхий газар	82.4	-3.3	2.0	-3.7	-1.6
23	Стандарт, хэмжил зүйн газар	81.6	14.2	-17.8	-4.8	-2.8
24	Биеийн тамир, спортын улсын хороо	81.4	-7.2	-7.9	-4.0	-6.3
25	Гадаадын иргэн харьяатын газар	80.7	-2.3	-7.5	-3.3	-4.4
26	Иргэний нисэхийн ерөнхий газар	80.3	4.6	2.4	-10.2	-1.1
27	Шүүх шинжилгээний ерөнхий газар	79.4	-2.6	-2.9	9.7	1.4
28	Гаалийн ерөнхий газар	78.7	5.3	10.4	10.1	8.6
29	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газар	77.9	-31.5	-3.5	-16.7	-17.2
30	Жижиг, дунд үйлдвэрийн газар	73.3	-22.5	-8.8	-28.9	-20.1
31	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	71.2	-28.4	-2.6	6.3	-8.2
32	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	70.9	-1.0	-42.9	-11.0	-18.3
33	Соёл урлагийн газар	67.8	-11.2	-23.1	-30.6	-21.6

⁴ Эдгээр нь өмнөх жил агентлагуудын авлигын индексийн эрэмбийн сүүлийн 7 байранд байсан байгууллагууд

34	Ашигт малтмал, газрын тосны газар	62.8	8.0	-5.3	8.0	3.6
	Агентлагуудын дундаж	84.0	6.1	2.1	2.2	3.5

Ашигт малтмал, газрын тосны газар хэдий авлигын индексийн үнэлгээ өссөн боловч өмнөх оноос нэг байр ухарч энэ оны сүүлийн эрэмбэд жагсаж байна. Жижиг, дунд үйлдвэрийн газар, Соёл урлагийн газар, Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газар зэрэг агентлагууд олон байраар ухарсан үр дүнтэй байна. Эдгээрээс Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газруудын авлигын талаарх төсөөлөл ихээр буурсан байна. Харин авлигын шууд бус тохиолдлын тооны өсөлтөөс шалтгаалж Жижиг, дунд үйлдвэрийн газар, Соёл урлагийн газрын шууд бус тохиолдлын оноо мөн л ихээр буурчээ. Агентлагууд авлигын индексийн асуулт тус бүрээр ямар үнэлгээтэй, ямар өөрчлөлттэй гүйцэтгэл үзүүлснийг Хавсралт 4, Хавсралт 8, Хавсралт 9-аас харан, энэ оны өөрчлөлтийн шалтгаанд дүгнэлт хийж болно.

2.4.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын индекс

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын дундаж авлигын индекс 70.1 буюу өмнөх оноос 0.8 оноогоор буурчээ. Нийт 22 ЗДТГ-аас 9 байгууллагын авлигын индекс буурсан, 11 байгууллагынх өссөн бол 2 байгууллага төдийлөн өөрчлөлтгүй байна. Түүнчлэн 5 аймаг ба нийслэлийн ЗДТГ-аас бусад байгууллагын авлигын индексийн үнэлгээ төрийн байгууллагуудын дундаж (77.9)-өөс бага байна. Дараах хүснэгтээс байгууллага тус бүр дэд үзүүлэлтээр хэрхэн өөрчлөгдсөнийг харах боломжтой бол индексэд хамаарах асуулт тус бүрийн оноо ба өөрчлөлтийг Хавсралт 4, Хавсралт 8, Хавсралт 9-аас харж болно.

2025 оны судалгаагаар Нийслэлийн ЗДТГ энэ бүлгийн авлигын индексийн жагсаалтыг тэргүүлж байна. Үүнд тус газрын авлигын шууд ба шууд бус тохиолдол буурсан, авлигын талаарх төсөөллийн асуултууд бүгд өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Хамгийн өндөр өсөлттэй нь Увс ба Хөвсгөл аймгуудын ЗДТГ-ууд байна. Тухайлбал, дурдсан хоёр аймгийн хувьд авлигын шууд ба шууд бус тохиолдлыг тоо энэ оны судалгаагаар бага гарсан, Увс аймгийн хувьд авлигын талаарх төсөөллийн асуултууд өссөн нь нөлөөтэй байна.

Хүснэгт 14. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2025 он

№	Байгууллагын нэр	Авлигын индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Нийслэлийн ЗДТГ	88.0	10.1	12.1	4.9	9.1
2	Төв аймгийн ЗДТГ	86.8	-4.3	-1.3	-8.0	-4.5
3	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	86.2	-0.7	-5.8	-3.0	-3.1
4	Дундговь аймгийн ЗДТГ	85.8	10.9	1.7	21.9	11.5
5	Увс аймгийн ЗДТГ	84.8	20.4	20.7	38.9	26.7
6	Хэнтий аймгийн ЗДТГ	81.8	2.9	2.0	-5.4	-0.2
7	Хөвсгөл аймгийн ЗДТГ	77.5	8.9	27.4	29.5	21.9
8	Өмнөговь аймгийн ЗДТГ	72.2	18.6	-36.3	27.0	3.1
9	Говь-Алтай аймгийн ЗДТГ	70.6	-2.8	-23.7	-14.0	-13.5
10	Архангай аймгийн ЗДТГ	69.7	8.2	-14.3	12.1	2.0
11	Завхан аймгийн ЗДТГ	69.3	-3.1	-6.0	-5.3	-4.8

12	Дорноговь аймгийн ЗДТГ	68.1	-10.5	-17.2	-4.3	-10.7
13	Булган аймгийн ЗДТГ	67.7	6.4	7.3	-6.8	2.3
14	Баян-Өлгий агийн ЗДТГ	67.6	-6.1	26.9	-7.8	4.4
15	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	65.4	23.0	-8.4	20.4	11.6
16	Орхон аймгийн ЗДТГ	61.5	0.4	18.0	-6.3	4.0
17	Баянхонгор аймгийн ЗДТГ	59.0	1.4	2.8	1.0	1.7
18	Ховд аймгийн ЗДТГ	58.5	-12.0	-9.3	-18.2	-13.2
19	Дорнод аймгийн ЗДТГ	57.5	2.1	4.8	-11.5	-1.5
20	Өвөрхангай аймгийн ЗДТГ	57.2	-23.8	-21.0	-27.0	-24.0
21	Сүхбаатар аймгийн ЗДТГ	54.7	-7.1	-13.7	-31.0	-17.3
22	Дархан-Уул аймгийн ЗДТГ	53.2	-8.7	-18.2	-45.6	-24.2
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд	70.1	1.6	-2.3	-1.8	-0.8

Дархан-Уул, Сүхбаатар, Өвөрхангай аймгуудын авлигын индекс их дүнгээр буурч сүүлийн байруудад жагссан байна. Дархан-Уул ба Сүхбаатар аймгуудын хувьд авлигын шууд бус тохиолдлын тоо, давтамж өссөнтэй голчлон холбоотой байгаа бол Өвөрхангай аймагт авлигын талаарх төсөөлөл мөн их буурчээ. ЗДТГ-ууд нь авлигын индексийн асуулт тус бүрээр ямар үнэлгээтэй, ямар өөрчлөлттэй гүйцэтгэл үзүүлснийг Хавсралт 4, Хавсралт 8, Хавсралт 9-аас харан, энэ оны өөрчлөлтийн шалтгаанд дүгнэлт хийж болно.

2.4.4 Чанарын асуултуудын үр дүн

Авлигын индексийн үнэлгээний хүрээнд авлигын шинжтэй үйлдлийн давтамж, үнийн дүн бүхий асуултууд мөн ГШБҮ-ний оноонд тооцогдохгүй, чанарын болон нээлттэй асуултуудыг албан хаагчдаас асуусан ба үр дүнг энэ хэсэгт танилцуулж байна.

Судалгаанд төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгсөн (асуулт А11), шууд болон шууд бус бэлэг өгсөн (асуулт А12), хандив, санхүүгийн туслалцаа үзүүлсэн (асуулт А13) эсэхийг тодруулсан. Эдгээр асуултуудад нийт судалгаанд оролцогчдын харгалзан 6.4%, 4.5% ба 3.7% нь тийм гэж хариулсан. Тухайн хариулт өгсөн иргэдийг аль төрлийн байгууллагад хамаарч байгааг харьцуулан харахад дараах байдалтай байна.

Хүснэгт 15. А11, А12, А13 асуултуудад өгсөн “тийм” хариултын тоо, байгууллагаар

Асуултын дугаар	Яам	Агентлаг	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Дүүргийн ЗДТГ	Хариултын нийт тоо
A11	128	116	394	55	693
A12	93	90	280	30	493
A13	78	73	220	30	401

Хүснэгт 15-с харахад “нэмэлт төлбөр өгсөн (асуулт А11)” хариултын тоо илүү олон байна. Гурван асуултад “тийм” гэж хариулсан давтамж аймаг, нийслэлийн ЗДТГ-аар үйлчлүүлэгчдэд хамгийн их бөгөөд яамдад хамаарах хариулт удаалж байна.

Аль байгууллагад албан хаагчдад нэмэлт төлбөр, бэлэг, хандив-санхүүгийн туслалцаа өгсөн гэсэн хариулт илүү олон байгааг харвал яамдаас Эрүүл мэндийн яам, Зам тээврийн яам, Боловсролын яамд, агентлагуудаас Ашигт малтмал, газрын тосны газар, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрууд зэрэг байгууллагад өгсөн хариултууд байна. Харин ЗДТГ-уудаас Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай,

Өмнөговь, Сэлэнгэ, Ховд зэрэг аймгуудад “тийм” гэсэн хариулт бусад аймгаасаа олон байна. Дүүргүүдийн ЗДТГ-уудаас Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын үйлчлүүлэгчид дийлэнх “тийм” хариултыг өгчээ (Хавсралт 10).

Дээрх гурван асуулт тус бүрийг нарийвчлан задалж, хэрэв эдгээр зүйлсийг өгсөн бол сүүлийн 12 сард өгсөн давтамж ба үнийн дүнг асуусан⁵. Авлигын шууд тохиолдол буюу төрийн албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр төлсөн давтамжаас харахад нэмэлт төлбөр төлсөн оролцогчдын 54.3 хувь нь нэг удаа, шууд болон шууд бус бэлэг өгсөн тохиолдлын 50.5 хувь нь нэг удаа, хандив туслалцаа үзүүлсэн тохиолдлын 49 хувь нь нэг удаа гэсэн хариултууд дийлэнх хувийг эзэлж байна. Нэмэлт төлбөр төлсөн хариултуудын 83% нь 500,000₮ хүртэлх төлбөр өгсөн гэж хариулжээ. Шууд болон шууд бус бэлэг өгсөн хариултуудын 85% нь 500,000₮ хүртэлх үнийн дүн бүхий бэлэг өгсөн гэж хариулсан. Харин 500,000₮ хүртэлх дүн бүхий хандив, санхүүгийн туслалцаа үзүүлсэн хариултын хувь 84% байна.

Цаашлаад хэрэв дээрх зүйлсийг өгсөн бол түүнийг “аль үед нь өгсөн (асуулт A14)”, “өгөх болсон шалтгааныг (асуулт A15)” тус тус асуусан. A14 асуултад өгсөн хариултуудын 29.7% нь үйлчилгээг авсны дараа, 26.3% нь авахаас өмнө, 19.4% нь үйлчилгээг авч байх үедээ өгдөг гэж хариулжээ. Эдгээр үр дүнг өмнөх онтой харьцуулахад үйлчилгээ авсны дараа өгдөг гэсэн хариулт 10.8 нэгж хувиар өссөн байгаа нь онцлог байна. Өмнөх онд үйлчилгээ авахаас өмнө өгдөг гэсэн хариулт 35%-ийг, үйлчилгээ авч байхдаа гэсэн хариулт 17.2%-ийн тус тус бүрдүүлж байжээ.

Зураг 8. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцааг ямар үед үзүүлсэн бэ? (A14)



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төрийн албан хаагчдад нэмэлт төлбөр өгсөн, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн, хандив туслалцаа үзүүлсэн шалтгааныг асуухад (A15) тус асуултад өгсөн хариултын 31.4% нь ажлаа хурдан бүтээхийн тулд, 26.5% нь хариуцлагаас зайлсхийхийн тулд, 16.8% нь давуу байдал олж авахын тулд зэрэг хариултуудыг түлхүү өгсөн байна. Тэгвэл 2024 онд хэвшмэл болсон гэсэн хариулт тухайн асуултад хариулсан утгын 29.7%-ийг бүрдүүлж байжээ. Харин хариуцлагаас зайлсхийхийн тулд гэсэн хариулт дөнгөж 1.6%-ийг эзэлж байсан бол энэ онд 26.5% болсон нь анхаарал татахуйц байна.

⁵ Асуултуудын дугаар A11-1, A11-2, A12-1, A12-2, A13-1, A13-2. Асуултын тавилыг Хавсралт 1-ээс харна уу.

Зураг 9. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцаа үзүүлэх болсон шалтгаан юу бэ?



Авлигын индексийн бүлэг асуултад “А17. Тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх шаардлагатай гэж Та үзэж байна вэ?” гэсэн нээлттэй асуултыг оролцогчдод тавьсан. Тус нээлттэй асуултад 6819 хариулт ирснийг бүлэглэвэл дараах үр дүнтэй байна. Үүнээс авлига, ашиг сонирхлын талаар мэдээллээр хангах, цалин хангамж, орлогыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, хяналтыг сайжруулах зэрэг хариултууд хамгийн их давтамжтай байгаа нь 2024 оныхтой адил байна.

Хүснэгт 16. Авлигыг бууруулах арга хэмжээний санал

№	Санал болгосон арга хэмжээ	Хариултын тоо
1	Авлига, ашиг сонирхлын талаар хийх, хуулийн мэдээллээр хангах	1013
2	Цалин хангамж, орлогыг нэмэгдүүлэх,	1008
3	Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах	797
4	Хяналтыг сайжруулах (байгууллагын дотоод хяналт, хараат бус хянал, аудиторын үйл ажиллагааг сайжруулах)	680
5	Улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах	344
6	Хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйтэй иргэдийг бий болгох	336
7	Хууль дүрмийг баримтлах, хүн бүрд тэгш үйлчилдэг байх	324
8	Шударга бус байдлыг бууруулах	323
9	Цахим үйлчилгээ нэвтрүүлж, хүний оролцоог багасгах	322
10	Хариуцлага тооцдог байх	217
11	Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчид өөрсдөө авлигал өгөхгүй байх	138
12	Хүнд суртлыг бууруулах	136
13	Холбогдох хууль тогтоомжийг сайжруулах	135
14	Төрийн алба хаагч хариуцлагатай байх	109
15	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах	98
16	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, амьжиргааны түвшин сайжруулах	94
17	Эрх зүйн орчныг сайжруулах, шинэчлэх, хатуу чанга болгох	85
18	Тогтолцоо буруу (Улс төр, засаглал, авлигын сүлжээ зэргийг тогтолцооны хувьд засах)	70
19	ТАХ-ын ажлын ачааллыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх	67
20	АТГ мэдээлэл өгсөн хүнийг нууцлах, авсан хүнийг шийтгэх, мэдээлэл өгөх тогтолцоог бий болгох	66
21	Төрийн байгууллагаас нам, улс төрийн оролцоо бууруулах	60

22	Ажиллах орчин сайжруулах	50
23	Эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг таслан зогсоох, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах	46
24	Татварыг бууруулах	46
25	Танил тал, хамаатан садны холбоо	45
26	Иргэдийн боловсролыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх	45
27	Ажлын байрны чиг үүргийг тодорхой болгож давхардлыг бууруулах	35
28	Ажлын шат дамжлагыг багасгах	29
29	Ашиг сонирхлын зөрчлийг арилгадаг байх	28
30	Удаан ажилласан хүмүүсийг өөрчилж байх	26
31	Уламжлалт буруу жишгээсээ салах (Гар цайлгах гэх мэт)	25
32	Ажилтантай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийдэг болох	10
33	Төрийн албанд мерит зарчим баримтлах	6
34	АТГ-ын үйл ажиллагааг сайжруулах	6

2.5 Дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ

Төрийн байгууллагын ШБҮ-д 2022 оноос эхлэн нийслэлийн 9 дүүргүүдийн ЗДТГ-ыг хамруулж эхэлсэн. Судалгааны үр дүнг өмнөх онуудтай харьцуулах боломжийг хангахын тулд төрийн байгууллагуудын ШБҮ болон түүний дэд үзүүлэлтүүдийн дундаж тооцоонд дүүргийн үнэлгээний утгуудыг оруулаагүй болно. Тиймээс энэ дэд хэсэгт 9 дүүргийн ЗДТГ-ын ГШБҮ ба бүрэлдэхүүн индексийн үнэлгээний дүнг тоймлов.

2025 онд дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ-ний дундаж 74.7 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 8.2 оноогоор өссөн бөгөөд энэ нь бусад төрийн байгууллагын дундаж үнэлгээнээс (ГШБҮ=71.4) өндөр байна. Дүүргүүдээс Хан-Уул ба Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ууд хамгийн өндөр үнэлгээг авсан бол Чингэлтэй ба Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хамгийн бага үнэлгээг авчээ. Энэ онд ГШБҮ нь өмнөх оноос буурсан ЗДТГ байгаагүй бөгөөд хамгийн их өсөлттэй нь Багахангай (26.1↑), Сонгинохайрхан (12.3↑) дүүргийн ЗДТГ-ууд байна. Хамгийн багадаа Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ийн ГШБҮ 1.2 оноогоор өсжээ.


Хүснэгт 17. Дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ, онуудаар

Дүүргүүд	2025	2024	2023	2022
Хан-уул дүүргийн ЗДТГ	78.4	68.2	67.9	75.5
Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	78.3	66	56.7	73.1
Багахангай дүүргийн ЗДТГ	77.5	51.4	69.6	73
Багануур дүүргийн ЗДТГ	76.5	70.8	65.1	66.1
Баянгол дүүргийн ЗДТГ	76.4	75.1	71.7	68.6
Налайх дүүргийн ЗДТГ	76.0	73.4	80.8	55.7
Баянзүрх дүүргийн ЗДТГ	71.1	60.3	80.7	59
Чингэлтэй дүүргийн ЗДТГ	70.1	67.2	75.5	58.7
Сүхбаатар дүүргийн ЗДТГ	67.6	66.4	84	66
Дүүргийн ЗДТГ-ын дундаж	74.7	66.5	72.4	66.2

Дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ-г хоёр дэд индексээр харвал авлигын эрсдэлийн индекс 65.2, авлигын индекс 84 оноогоор тус тус үнэлэгдэж, өмнөх оноос харгалзан 3.8 ба 12.4 оноогоор өссөн байна. Бусад төрлийн төрийн байгууллагатай адил авлигын эрсдэлийн индекс нь авлигын индексээс 20 орчим оноогоор бага үнэлгээтэй байсаар байна. Өөрөөр хэлбэл, иргэд ШБҮ-ний асуулгын дагуу ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангалтгүй гэж тодорхойлсон хэвээр байна. Өмнөх 2.3 ба 2.4 дэх хэсгүүдэд

танилцуулсны адил, дүүргүүдийн хоёр дэд индексийн үнэлгээ 2024 оны судалгаагаар буурч, энэ онд эргээд өссөн байна.

Зураг 10. Дүүргүүдийн ГШБҮ-ний дэд индексийн үнэлгээ, онуудаар



Дараах хүснэгтэд авлигын эрсдэлийн индекс, түүний дэд үзүүлэлтүүдийг дүүргүүдээр задлан харуулав. Дүүргүүдийн дундаж ил тод байдлын үзүүлэлт 61.1 оноогоор (2.5↑), хариуцлагатай байдлын үзүүлэлт 69.4 (5.1↑) оноогоор тус тус үнэлэгдсэн байна (Хавсралт 3). Хэдийгээр бүх дүүргийн ЗДТГ-уудын ГШБҮ өмнөх оноос өссөн боловч авлигын эрсдэлийн индекс зарим байгууллагын хувьд буурсан эсвэл төдийлөн өөрчлөлтгүй байгааг доорх хүснэгтээс харж болно.

Энэхүү хоёр дэд үзүүлэлтийг 4 асуултаар үнэлдэг ба Хавсралт 4-с харахад тухайн байгууллагын төсөв, санхүү, худалдан авалтын ил тод байдлын дундаж үнэлгээ 1.85 оноогоор буурсан бол бусад гурван асуулт өссөн үнэлгээтэй байна. Энэ онд авлигын эрсдэлийн индексээр дүүргүүд дунд Хан-Уул дүүрэг тэргүүлсэн ч үнэлгээний оноо 70 байгаа нь цаашид ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх шаардлага байсаар байна. Хамгийн өндөр өсөлттэй байгууллага нь Багахангай дүүргийн ЗДТГ байна. Хамгийн их бууралттай бөгөөд бага үнэлгээтэй нь Чингэлтэй дүүргийн ЗДТГ байна. Хавсралт 4 ба Хавсралт 6-аас байгууллага тус бүрээр үнэлгээний нэгж асуултын 2025 оны үр дүн ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг харах боломжтой. Тухайлбал, Чингэлтэй дүүргийн хувьд төсөв, санхүү, худалдан авалтын ил тод байдлыг 49 оноогоор (21↓), үйлчилгээ үзүүлэх үеийн хүчин чармайлтыг 62 оноогоор (7.9↓), үйлчилгээний ёс зүйн байдлыг 63 оноогоор (7.5↓) тус тус үнэлсэн байна.

Хүснэгт 18. Дүүргүүдийн ЗДТГ-ын авлигын эрсдэлийн индекс, дэд үзүүлэлтийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	70.0	-4.5	1.2	-1.7
2	Багахангай дүүргийн ЗДТГ	69.0	22.4	22.4	22.4
3	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	68.1	-6.3	5.5	-0.4
4	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	67.0	5.1	8.7	6.9
5	Баянгол дүүргийн ЗДТГ	66.7	3.1	-6.9	-1.9
6	Налайх дүүргийн ЗДТГ	65.5	5.1	12.6	8.9
7	Багануур дүүргийн ЗДТГ	64.1	10.7	5.1	7.9
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	59.3	-0.9	5.4	2.2
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	57.2	-12.3	-7.7	-10.0
Дундаж үнэлгээ		65.2	2.5	5.1	3.8

Авлигын индекс, түүний бүрэлдэхүүн үзүүлэлтүүдээр дүүргийн ЗДТГ-ууд ямар үнэлгээтэй байсныг хүснэгт 18-д тоймлов. Тус индекс өмнөх оноос 13.3 оноогоор өсөхөд авлигын шууд тохиолдол ба шууд бус тохиолдлын үнэлгээ нэмэгдсэн нөлөөлжээ. Энэ онд судалгаанд хамрагдсан оролцогчдын туршлагаар авлигын шууд ба шууд бус тохиолдлын тоо өмнөх оноос бага байлаа. Дүүргүүдийн дундаж авлигын талаарх төсөөлөл 68.8 (8.3↑), авлигын шууд тохиолдол 90.4 (14.8↑), авлигын шууд бус тохиолдол 93 (14.1↑) оноогоор тус тус үнэлэгдсэн байна (Хавсралт 3).

Хүснэгт 19. Дүүргүүдийн ЗДТГ-ын авлигын индекс, дэд үзүүлэлтийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Багануур дүүргийн ЗДТГ	88.8	1.8	26.1	11.0	13.0
2	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	88.6	18.7	15.8	12.9	15.8
3	Хан-Уул дүүргийн ЗДТГ	86.8	12.4	30.1	12.1	18.2
4	Налайх дүүргийн ЗДТГ	86.5	-7.1	11.3	16.9	7.0
5	Баянгол дүүргийн ЗДТГ	86.2	5.0	4.4	-0.4	3.0
6	Багахангай дүүргийн ЗДТГ	86.0	24.2	37.1	28.2	29.8
7	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	83.0	-5.0	39.6	12.7	15.8
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	82.9	15.6	-1.9	30.4	14.7
9	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	68.1	8.8	-29.1	3.0	-5.8
Дундаж үнэлгээ		84	8.3	14.8	14.1	12.4

Авлигын индексийн дээрх 3 дэд үзүүлэлтийг 16 асуултаар үнэлдэг ба Хавсралт 4 дээрх нэгж асуулт бүрийн энэ оны үнэлгээнээс харахад авлигын төсөөллийн талаарх 6 асуултын дундаж үнэлгээ нь 66 – 71 онооны хооронд байна. Харин авлигын шууд тохиолдлыг үнэлэх 9 асуултуудын дундаж үнэлгээ нь 82 – 98 онооны хооронд байна. Нэгж асуултуудын өөрчлөлтийг Хавсралт 8 ба Хавсралт 9-с харахад сүүлийн 12 сарын хугацаанд нэмэлт төлбөр, бэлэг, санхүүгийн туслалцаа өгсөн давтамжийн тоо энэ онд буурснаар холбогдох А11-1, А12-1, А13-1 асуултуудын дүүргүүдийн дундаж үнэлгээ харгалзан 44, 31, 27 оноогоор нэмэгдсэн байна.

Энэ онд авлигын индексээр дүүргүүд дунд Багануур дүүргийн ЗДТГ тэргүүлж, Багахангай дүүрэг мөн л хамгийн өндөр индексийн өсөлттэй ЗДТГ байлаа. Дүүргийн ЗДТГ-ууд дунд авлигын индексийн үнэлгээ буурсан ганц байгууллага нь Сүхбаатар дүүргийн ЗДТГ бөгөөд авлигын шууд тохиолдлын давтамж, мөнгөн дүн өмнөх жилээс өндөр байсантай холбоотой байна.

Хавсралт 4, Хавсралт 8 ба Хавсралт 9-с байгууллага тус бүрээр үнэлгээний нэгж асуултын 2025 оны үр дүн ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг харах боломжтой.

2.6 ГШБҮ-ний гүйцэтгэл бага байгууллагууд

Энэ хэсэгт 2025 онд хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудын дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг байгууллага тус бүрээр авч үзье.

1. Сүхбаатар аймгийн ЗДТГ

ГШБҮ-ний эрэмбийн хамгийн сүүлд орсон Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын үнэлгээний 5 дэд үзүүлэлтүүдийн үр дүн ба өөрчлөлтийг дараах хүснэгтэд харуулав. Тус байгууллагын индексийн үзүүлэлтүүд 4-31 оноогоор буурч үнэлэгджээ. Улмаар авлигын эрсдэлийн

индекс 40.9 оноотой, авлигын индекс 58.6 оноотой байна. Үр дүнд нь нийт ГШБҮ нь 50 хүрэхгүй хувьтай үнэлэгдсэн нь тухайн байгууллагад олон нийтийн итгэл маш бага байна.

Хүснэгт 20. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ГШБҮ-ний үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ГШБҮ	60.4	47.8	-12.5
I. Авлигын эрсдэлийн индекс	48.7	40.9	-7.8
Ил тод байдал	45.6	33.6	-12
Хариуцлагатай байдал	51.9	48.3	-3.6
II. Авлигын индекс	72.0	54.7	-17.3
Авлигын талаарх төсөөлөл	54.3	47.2	-7.1
Авлигын шууд тохиолдол	73.8	60.1	-13.7
Авлигын шууд бус тохиолдол	87.9	56.9	-31

Байгууллагын үзүүлэлтээс авлигын эрсдэлийн индексийг задалж үзвэл

- Тухайн байгууллагын ил тод байдлыг илэрхийлдэг үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл 33.4 оноо (16.3↓), төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 33.8 (7.7↓) оноогоор тус тус үнэлэгдсэн байна. Эдгээр асуулт тус бүрд нийт 180 хүний 26 нь л ил тод байдалтай санал нийлнэ ба бүрэн санал нийлнэ гэж хариулсан байна. Тиймээс цаашид үйлчлүүлэгчдэд хамааралтай, хэрэгтэй мэдээллийн ил тод байдал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.
- Харин тухайн байгууллагын хариуцлагатай байдлыг илэрхийлдэг албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилласан байдал нь 44.1 (6.5↓) оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 52.5 (0.7↓) оноогоор тус тус үнэлэгджээ. Тухайлбал, судалгаанд орсон 180 хүний 18 хувь нь хүчин чармайлт гаргаж ажилласан гэдэгт санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэсэн бол ёс зүйгүй үйлдэл гаргасан гэдэгт 21 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын индексийн үнэлгээг задалбал:

- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 7.1 оноогоор буурсан байна. Үүнд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ:
 - бусдад дарамт, шахалт үзүүлдэг байдалд 51.7 (10.3 ↓) онооны үнэлгээ буюу тухайн байгууллагыг үнэлсэн нийт хүмүүсийн 22% нь санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэж үзсэн байна.
 - ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдалд 52 хувь нь санал нийлж болон бүрэн санал нийлж байгаа ба 35.9 (14.9↓) оноогоор үнэлжээ.
 - хууль бусаар давуу байдал олгодог байдалд 43.8 (7.0↓) оноо, бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн 49.4 (4.5↓) онооны үнэлгээг иргэд өгсөн байна.
 - хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдалд 49.3 (3.7↓) оноо, хувийн ашиг сонирхлоор хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй үйлдлийг хийдэг явдалд 53.1 (2.4↓) оноогоор тус тус үнэлжээ.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 60.1 ба өмнөх оноос 13.7 оноогоор буурахад сүүлийн 12 сарын хугаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ

- Нэмэлт төлбөр авсан байдал 79.4 (8.2↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж (55.4↓), мөнгөн дүн (39.2↓) зэрэг үзүүлэлтүүд буурсан явдал
- Шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг явдал 4.9 оноогоор өссөн байна. Бэлэг өгсөн давтамж 5 оноогоор өссөн боловч 35.5 онооны үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ өмнөх оноос өндөр байснаар 30.4 (57.8↓) үнэлгээтэй,
- Хандив, туслалцаа авсан байдал 6.6 оноогоор өсөж үнэлэгдсэн бөгөөд түүний давтамж, мөнгөн дүнгийн хэмжээ өмнөх оноос бага байснаар харгалзан 6.3 ба 14.9 оноогоор өссөн байна. Тус байгууллагын хувьд нэмэлт төлбөр, бэлэг зэрэг тохиолдлын давтамжаас илүү ихээр хэмжээний мөнгөн дүн өндөр байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 33% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба 31 оноогоор буурч, 56.9 оноогоор үнэлэгдсэн.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтүүд өмнөх онд мөн л бага үнэлгээтэй байсан бол энэ онд түүнээсээ дахин буурсан үр дүнтэй байна. Тус аймгийн цахим хуудсан дахь нийтэд нээлттэй мэдээллээс харахад 2024 онд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулаагүй буюу түүнийг хэрэгжүүлсэн эсэх мэдээлэл байхгүй байлаа. Өөрөөр хэлбэл, өмнөх оны ШБҮ-ний үр дүнд суурилсан арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. Ил тод байдлын хувьд хүний нөөцийн сонгон шалгаруулалт, сул орон тооны мэдээлэл хамгийн сүүлд 2023 онд шинэчлэгдсэн байх жишээтэй.

2. Өвөрхангай аймгийн ЗДТГ

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын ГШБҮ энэ онд 49.2 оноогоор үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оноос өндөр дүнгээр буюу 21.7 оноогоор буурсан үзүүлэлт юм. Үүнд авлигын эрсдэлийн индекс ба авлигын индекс тус бүр 20 орчим оноогоор буурсан нь нөлөөтэй байна. Үнэлгээний 5 дэд үзүүлэлтүүд ч мөн хоёр оронтой тоогоор буурсан байна.

Хүснэгт 21. Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын ГШБҮ-ний үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ГШБҮ	70.8	49.1	-21.6
I. Авлигын эрсдэлийн индекс	60.5	41.1	-19.4
Ил тод байдал	51.3	35.3	-16
Хариуцлагатай байдал	69.7	47.0	-22.7
II. Авлигын индекс	81.2	57.2	-24.0
Авлигын талаарх төсөөлөл	68.2	44.4	-23.8
Авлигын шууд тохиолдол	91.6	70.6	-21
Авлигын шууд бус тохиолдол	83.7	56.7	-27

Авлигын эрсдэлийн индексийг задалж үзвэл:

- Тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 34.4 (29.1↓) оноо, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 36.1 (3.1↓) оноогоор тус тус үнэлэгдсэн буюу иргэдийн ил тод байдлын сэтгэл ханамж 50 хувьд ч хүрэхгүй байна.

- Харин тухайн байгууллагын хариуцлагатай байдлыг илэрхийлдэг албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал нь 42.3 (28.5↓) оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 51.8 (16.7↓) оноогоор тус тус үнэлэгджээ. Тухайлбал, судалгаанд орсон 180 хүний 15 хувь нь хүчин чармайлт гаргаж ажилласан гэдэгтэй санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэсэн бол ёс зүйгүй үйлдэл гаргасан гэсэн хариулттай 21 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын индексийн үнэлгээг задалбал:

- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 23.8 оноогоор буурсан нь анхаарах шаардлагатай үр дүн байна. Үүнд тухайн байгууллагын алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ:
 - бусдад дарамт, шахалт үзүүлдэг байдалд 50.2 (22.7 ↓) онооны үнэлгээ буюу тухайн байгууллагыг үнэлсэн нийт хүмүүсийн 25 хувь нь санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэж үзсэн байна.
 - ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдалд 63 хувь нь санал нийлж болон бүрэн санал нийлж байгаа ба 30.1 (32.8↓) оноогоор үнэлжээ.
 - хууль бусаар давуу байдал олгодог байдалд 42.1 (22.3↓) оноо өгч өмнөх оноос үнэлгээ өссөн ч тухайн байгууллагыг үнэлж буй иргэдийн 37% нь давуу байдал олгож байгаатай санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.
 - бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдалд 46.1 (20.4↓) онооны үнэлгээг буюу үнэлгээ өгсөн иргэдийн 26 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.
 - хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдалд 47.1 (22.9↓) оноо, хувийн ашиг сонирхлоор хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй үйлдлийг хийдэг байдлыг 50.7 (22↓) оноогоор тус тус үнэлжээ.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 70.6 ба өмнөх оноос 21 оноогоор буурсан байна. Үүнд сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ
 - Нэмэлт төлбөр авсан байдал 81.4 (15.7↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 9.3 (39.8↓), мөнгөн дүн 56.1 (5.2↓) зэрэг оноогоор үнэлсэн байна. Тухайлбал, нийт 180 хүнээс 33 нь өмнөх 12 сарын хугацаанд нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үүнээс 21 хүн нэг удаа өгсөн гэсэн бол 9 хүн хоёр удаа өгсөн гэжээ.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг байдалд өгсөн үнэлгээ 3.1 оноогоор буурч 93.3 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан учир 52.7 (28.0↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 94.1 (2.1↓) үнэлгээтэй тус тус байна. Өмнөх онд тус байгууллага нь сүүлийн 12 сард шууд ба шууд бус бэлэг авсан давтамжийн тоогоор хамгийн өндөр нь байжээ.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 95.5 (2.7↓) оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж 65.1 (26.8↓), мөнгөн дүнгийн хэмжээ 88.4 (4.3↓) гэсэн үнэлгээтэй байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 31% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үнэлгээ нь 27 оноогоор буурч, 56.7 оноогоор үнэлэгдсэн.

3. Дорнод аймгийн ЗДТГ

Дорнод аймгийн ЗДТГ-ын ГШБҮ энэ онд бараг өөрчлөлтгүй байсан ба өмнөх онтой адил хойгуур эрэмбэд орсон байна. Доорх хүснэгтээс харахад нэг үзүүлэлтийн бууралт нь нөгөө үзүүлэлтийн өсөлтөөр нөхөгдөх байдлаар ГШБ-ын нийт үнэлгээнд бага өөрчлөлт гарчээ. Тухайлбал, ил тод байдал 6.4 оноогоор буурсан ч хариуцлагатай байдал 5.7 оноогоор өссөн байна. Авлигын шууд тохиолдол ба шууд бус тохиолдлыг үзүүлэлтэд мөн адил үр дүнг харуулжээ.

Хүснэгт 22. Дорнод аймгийн ЗДТГ-ын ГШБҮ-ний үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ГШБҮ	50.1	49.2	-0.9
I. Авлигын эрсдэлийн индекс	41.3	41.0	-0.3
Ил тод байдал	41.3	34.9	-6.4
Хариуцлагатай байдал	41.3	47.1	5.7
II. Авлигын индекс	59.0	57.5	-1.5
Авлигын талаарх төсөөлөл	42.3	44.5	2.1
Авлигын шууд тохиолдол	70.3	75.2	4.8
Авлигын шууд бус тохиолдол	64.3	52.8	-11.5

Авлигын эрсдэлийн индексийг задалж үзвэл

- Тухайн байгууллагын ил тод байдлыг илэрхийлдэг үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл 35 (4.8↑) оноо, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 35 (17.6↓) оноогоор тус тус үнэлэгдсэн байна. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдалд 51 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж хариулсан байна.
- Харин тухайн байгууллагын хариуцлагатай байдлыг илэрхийлдэг албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал нь 43 (6.3↑) оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 51 (5.2↑) оноогоор тус тус үнэлэгджээ. Тухайлбал, судалгаанд орсон 180 хүний 18 хувь нь хүчин чармайлт гаргаж ажилладаг байдалтай санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэсэн бол ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдалтай 24 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.

Дорнод аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын индексийн үнэлгээг задалбал:

- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 2.1 оноогоор өссөн байна. Үүнд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ:
 - бусдад дарамт, шахалт үзүүлдэг байдалд 50.5 (5.5 ↑) онооны үнэлгээ буюу тухайн байгууллагыг үнэлсэн нийт хүмүүсийн 20% нь санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэж үзсэн байна.
 - ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдалд 52 хувь нь санал нийлж болон бүрэн санал нийлж байгаа ба 34.7 (0↑↓) оноогоор үнэлжээ.
 - хууль бусаар давуу байдал олгодог байдалд 42.2 (6.6↑) оноо өгч өмнөх оноос үнэлгээ өссөн ч тухайн байгууллагыг үнэлж буй иргэдийн 34% нь давуу байдал олгож байгаатай санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.
 - бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдалд 45.5 (0.7↑) онооны үнэлгээг иргэд өгсөн байна.
 - хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдалд 44.7 (1.7↑) оноо, хувийн ашиг сонирхлоор хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй үйлдлийг хийдэг байдлыг 49.4 (1.7↓) оноогоор тус тус үнэлжээ.

- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 82.4 ба өмнөх оноос 12 оноогоор өсчээ. Үүнд сүүлийн 12 сарын хугаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ
 - Нэмэлт төлбөр авсан байдал 80.9 (6↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 7.0 (27.8↓), мөнгөн дүн 82.1 (3.7↑) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг байдалд өгсөн үнэлгээ 3.1 оноогоор өсөж 92.5 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан учир 61.7 (61.7↑)⁶ үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 92.4 (0.2↓) үнэлгээтэй тус тус байна. Өмнөх онд тус байгууллага нь сүүлийн 12 сард шууд ба шууд бус бэлэг авсан давтамжийн тоогоор хамгийн өндөр нь байжээ.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 93.6 оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж, мөнгөн дүнгийн хэмжээ өмнөх оноос бага байснаар харгалзан 20.6 ба 3.5 оноогоор тус тус өссөн байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 33% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба 11.5 оноогоор буурч, 52.8 оноогоор үнэлэгдсэн.

4. Ховд аймгийн ЗДТГ

Ховд аймгийн ЗДТГ-ын ГШБҮ энэ онд 13.4 оноогоор буурч 51.6 гэсэн үнэлгээнд хүрээд байна. Энэ онд авлигын эрсдэлийн индексийн бууралт 13.7, авлигын индексийн бууралт 13.2 оноо байна. Үнэлгээний дэд үзүүлэлтүүд бүгд бууралттай байна.

Хүснэгт 23. Ховд аймгийн ЗДТГ-ын ГШБҮ-ний үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ГШБҮ	65.0	51.6	-13.4
I. Авлигын эрсдэлийн индекс	58.4	44.7	-13.7
Ил тод байдал	52.5	39.2	-13.3
Хариуцлагатай байдал	64.3	50.3	-14.0
II. Авлигын индекс	71.6	58.5	-13.2
Авлигын талаарх төсөөлөл	59.3	47.4	-12.0
Авлигын шууд тохиолдол	79.4	70.0	-9.3
Авлигын шууд бус тохиолдол	76.2	58.0	-18.2

Тус ЗДТГ-ын авлигын эрсдэлийн индексийн үнэлгээг задалж, шинжилбэл:

- Тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 38.6 (17.3↓) оноо, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 39.7 (9.3↓) оноогоор тус тус үнэлэгдсэн буюу иргэдийн ил тод байдлын сэтгэл ханамж 50 хувьд ч хүрэхгүй байна. Тухайлбал, тус ЗДТГ-ыг үнэлсэн 180 хүний 48% нь хүний нөөцийн ил тод байдлыг, 44% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Харин тухайн байгууллагын хариуцлагатай байдлыг илэрхийлдэг албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилласан байдал нь 46.4 (18.1↓) оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 54.2 (9.9↓) оноогоор тус тус үнэлэгджээ.

⁶ Өмнөх онд 0 үнэлгээ авч байсан байна.

Тухайлбал, судалгаанд орсон 180 хүний 10 хувь нь хүчин чармайлт гаргаж ажилласан гэж санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэсэн бол ёс зүйгүй үйлдэл гаргасан гэдэгтэй 26 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.

Ховд аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын индексийн үнэлгээг задалбал:

- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 7.1 оноогоор буурсан ба үүнд тухайн байгууллагын алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ:
 - бусдад дарамт, шахалт үзүүлдэг байдалд 52.1 (7.4 ↓) онооны үнэлгээ буюу тухайн байгууллагыг үнэлсэн нийт хүмүүсийн 23 хувь нь санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэж үзсэн байна.
 - ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдалд 52 хувь нь санал нийлж болон бүрэн санал нийлж байгаа ба 35.3 (26.8 ↓) оноогоор үнэлжээ.
 - хууль бусаар давуу байдал олгодог байдалд 46 (10.6 ↓) оноо өгч өмнөх оноос үнэлгээ өссөн ч тухайн байгууллагыг үнэлж буй иргэдийн 29 хувь нь давуу байдал олгож байгаатай санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.
 - бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдалд 49.2 (10.7 ↓) онооны үнэлгээг буюу үнэлгээ өгсөн иргэдийн 19 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.
 - хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдалд 49.5 (7.9 ↓) оноо, хувийн ашиг сонирхлоор хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй үйлдлийг хийдэг байдлыг 52.1 (8.3 ↓) оноогоор тус тус үнэлжээ.
- Ховд аймгийн ЗДТГ-ын авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 79.4 ба өмнөх оноос төдийлөн өөрчлөлтгүй байна. Сүүлийн 12 сарын хугааанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 84.3 (9.6 ↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 25.6 (48 ↓), мөнгөн дүн 59.2 (59.2 ↑)⁷ зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг байдалд өгсөн үнэлгээ 2.8 оноогоор буурч 93.8 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан учир 59.1 (23.7 ↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 94.5 (2.4 ↑) үнэлгээтэй тус тус байна.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 93.9 (2.7 ↓) оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж 39.4 (49.3 ↓), мөнгөн дүнгийн хэмжээ 80.6 (9.4 ↓) гэсэн үнэлгээтэй байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 31% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үнэлгээ нь 18.2 оноогоор буурч, 58 оноогоор үнэлэгдсэн.

5. Боловсролын яам

Тус яамны ГШБҮ энэ онд 9 оноогоор буурч 52.4 гэсэн үнэлгээнд хүрээд байна. Энэ онд авлигын эрсдэлийн индексийн бууралт 10.2, авлигын индексийн бууралт 7.9 оноо байна.

⁷ Өмнөх онд өгсөн нэмэлт төлбөрийн дундаж дүн хамгийн өндөр байгууллага буюу тус нэгж асуултад 0 үнэлгээ авч байсан.

Авлигын шууд бус тохиолдлоос бусад дэд үзүүлэлт бүгд бууралттай бөгөөд 60 хүрэхгүй үнэлгээ авсан байна.

Хүснэгт 24. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ГШБҮ-ний үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ГШБҮ	61.4	52.4	-9.0
I. Авлигын эрсдэлийн индекс	55.8	45.6	-10.2
Ил тод байдал	54.0	43.5	-10.5
Хариуцлагатай байдал	57.6	47.8	-9.8
II. Авлигын индекс	67.0	59.1	-7.9
Авлигын талаарх төсөөлөл	54.8	48.1	-6.7
Авлигын шууд тохиолдол	82.2	53.7	-28.5
Авлигын шууд бус тохиолдол	64.1	75.6	11.5

Боловсролын яамны авлигын эрсдэлийн индексийн үнэлгээг задалж, шинжилбэл:

- Тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 42.8 (10.4↓) оноо, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 44.2 (10.6↓) оноогоор тус тус үнэлэгдсэн буюу иргэдийн ил тод байдлын сэтгэл ханамж маш бага байна. Тухайлбал, тус яамыг үнэлсэн 180 хүний 36% нь хүний нөөцийн ил тод байдлыг, 32% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Харин тухайн байгууллагын хариуцлагатай байдлыг илэрхийлдэг албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал нь 46.6 (5.7↓) оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 49 (14.0↓) оноогоор тус тус үнэлэгджээ. Судалгаа өгсөн 180 хүний 21 хувь нь тухайн байгууллагын албан хаагч нь хүчин чармайлт гаргаж ажилласан хэмээн санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэсэн бол үйлчилгээ үзүүлэх үедээ ёс зүйгүй үйлдэл гаргасан гэдэгт 21 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.

Тухайн яамны авлигын индексийн үнэлгээг задалбал:

- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 6.2 оноогоор буурсан ба үүнд тухайн байгууллагын алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ:
 - бусдад дарамт, шахалт үзүүлдэг байдалд 48.1 (11.1↓) онооны үнэлгээ буюу тухайн байгууллагыг үнэлсэн нийт хүмүүсийн 26 хувь нь санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэж үзсэн байна.
 - ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдалд 30 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлж байгаа ба 46 (3.7↓) оноогоор үнэлжээ.
 - хууль бусаар давуу байдал олгодог байдалд 45.8 (3.5↓) оноо өгч өмнөх оноос үнэлгээ өссөн ч тухайн байгууллагыг үнэлж буй иргэдийн 32 хувь нь давуу байдал олгож байгаатай санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.
 - бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдалд 46.7 (7.4↓) онооны үнэлгээг буюу үнэлгээ өгсөн иргэдийн 29 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэжээ.

- хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдалд 48.6 (10.9↓) оноо, хувийн ашиг сонирхлоор хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй үйлдлийг хийдэг байдлыг 53.3 (3.4↓) оноогоор тус тус үнэлжээ.
- Тус яамны авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 53.7 ба өмнөх оноос 28.5 оноогоор буурсан. Сүүлийн 12 сарын хугаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 88.6 (4.3↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 58.1 (9.7↓), мөнгөн дүн 53.6 (25.2↓) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг байдалд өгсөн үнэлгээ 6.5 оноогоор буурч 87.2 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос өндөр буюу 27.4 (40.3↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 31.9 (64.2↓) үнэлгээтэй тус тус байна.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 84.8 (8.8↓) оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж 29.8 (48.4↓), мөнгөн дүнгийн хэмжээ 21.9 (48.9↓) гэсэн үнэлгээтэй байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 17% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үнэлгээ нь 11.5 оноогоор өсч, 75.6 оноогоор үнэлэгдсэн байна.

Бүлэг 3. МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН ТӨСӨӨЛӨЛ


Энэ бүлэгт Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл, авлига хамгийн их тархсан институтын талаар, ирэх 2 жил авлигын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл болон АТГ-ын үйл ажиллагааг төрийн үйлчилгээ авч буй иргэд хэрхэн үнэлснийг харууллаа.

3.1 Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал

Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдлыг судалгаанд оролцогчдоос асуухад, Монгол улсад авлига түгээмэл байна гэж судалгаанд оролцогчдын 39.7 хувь нь хариулжээ. Харин ихээхэн түгээмэл гэж судалгаанд оролцогчдын 15.2 хувь нь хариулсан бол, 20.1 хувь нь дунд зэрэг, 6.5 хувь нь бага, 2.7 хувь нь огт байхгүй, 15.9 хувь нь мэдэхгүй буюу хариулахаас татгалзсан байна. 2024 онтой харьцуулахад ихээхэн түгээмэл гэж хариулсан оролцогчдын хувь 1.4 пунктээр, түгээмэл гэж хариулсан оролцогчдын хувь 1 пунктээр тус тус буурсан бол, дунд зэрэг гэж хариулсан оролцогчдын хувь 1.2 пунктээр, бага гэж хариулсан оролцогчдын хувь 0.5 пунктээр өссөн байна. Огт байхгүй гэж хариулсан оролцогчдын хувь 1.3 пунктээр буурч харин мэдэхгүй/хариулахаас татгалзсан оролцогчдын хувь 1.4 пунктээр тус тус өсжээ.

2025 онд авлига нь түгээмэл, ихээхэн түгээмэл байдаг гэсэн төсөөлөл өмнөх оноос буурч, харин дунд зэрэг болон бага гэсэн төсөөллүүд өссөн байна. Өөрөөр хэлбэл, хэдий өөрчлөлтийн хувь бага боловч өмнөх оны хандлагыг энэ онд мөн хадгалсан байна. Хэдий тийм боловч хариултуудын дундаж оноог 100 хүртэлх үнэлгээнд шилжүүлбэл 32.7 оноотой буюу иргэдийн авлигын талаарх төсөөлөл маш бага үнэлэмжтэй байна⁸.

Зураг 11. Монгол улсад авлига хэр түгээмэл байна вэ?, хувиар, сүүлийн 5 жилээр



Авлигын түгээмэл байдлын төсөөллийг судалгаанд оролцогчдын насны бүлгээр хэрхэн хариулсан хувийн жинг дараах хүснэгтэд харууллаа. Бүх насны бүлгийн хувьд тэдний

⁸ Ихээхэн түгээмэл – 0 оноо, Түгээмэл – 25 оноо, Дунд зэрэг – 50 оноо, Бага – 75 оноо, Огт байхгүй – 100 оноо гэж шилжүүлэв.

хариултын дийлэнх хувь нь “түгээмэл” гэсэн сонголттой байна. Харин 20 хүртэл насны болон 60-аас дээш насны иргэдийн хариулт бусад насны иргэдээс ялгаатай байна. Тухайлбал, 20 хүртэлх насны иргэдийн хувьд “түгээмэл” гэсэн хариулт нийт хариултын 26%-ийг бүрдүүлж байгаа бол бага гэсэн хариулт 10%-ийг, огт байхгүй гэсэн хариулт 4%-ийг бүрдүүлж байна. 60-аас дээш насны оролцогчид мөн мэдэхгүй гэсэн хариултын хувь бусад насныхнаас илүү өндөр, авлига бага гэсэн хариултын хувь бусдаас бага байх жишээтэй.


Хүснэгт 25. Авлигын түгээмэл байдлын төсөөллийн хариултын хувийн жин, насны бүлгээр

	Насны бүлэг					
	20 хүртэл	20-29	30-39	40-49	50-59	60-с дээш
Ихээхэн түгээмэл	16%	15%	15%	16%	14%	16%
Түгээмэл	26%	39%	42%	40%	39%	37%
Дунд зэрэг	21%	22%	21%	20%	18%	17%
Бага	10%	7%	6%	6%	7%	4%
Огт байхгүй	4%	2%	3%	2%	3%	3%
Мэдэхгүй/хариулахаас татгалзсан						
Нийт	23%	14%	14%	15%	19%	22%
	100%	100%	100%	100%	100%	100%

Тайлбар: Хариултын хувийн жинг багаас их рүү ногооноос, улаан өнгө рүү тэмдэглэсэн байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол улсын ирэх 2 жилийн авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар асуухад, судалгаанд хамрагдсан хүмүүсийн 32.8 хувь нь өөрчлөгдөхгүй, 19.1 хувь нь өснө, 13.6 хувь нь буурна, 5.4 хувь нь их өснө, 1.9 хувь нь их буурна, 27.2 хувь нь мэдэхгүй гэж тус тус хариулжээ. 2024 онтой харьцуулахад үнэмлэхүй өөрчлөлт байхгүй боловч өмнөх авлигын төсөөллөөс арай өөр үр дүн буюу авлига өснө эсвэл өөрчлөгдөхгүй гэсэн хандлага давамгайлж эхэлж байна. Хариултуудын дундаж утгыг 100 хүртэлх оноонд шилжүүлбэл 45.7 гэсэн үнэлгээтэй байна⁹.

Зураг 12. Ирэх 2 жилд Монгол улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ? хувиар, сүүлийн 5 жилээр



⁹ Их өснө – 0 оноо, өснө – 25, өөрчлөгдөхгүй – 50, Буурна – 75 оноо, Их буурна – 100 гэж шилжүүллээ.

Монгол улсын ирэх 2 жилийн авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар хариултыг насны бүлгээр авч үзвэл 20 хүртэлх нас ба 60-аас дээш насныханд мэдэхгүй гэсэн хариултын хувь хамгийн өндөр байгаа нь өмнөх асуулт дээрх хандлагатай адил байна.

Хүснэгт 26. Авлигын ирэх 2 жилийн төсөөллийн хариултын хувийн жин, насны бүлгээр

	Насны бүлэг					
	20 хүртэл	20-29	30-39	40-49	50-59	60-с дээш
Их өснө	8%	6%	5%	5%	5%	7%
Өснө	21%	20%	21%	18%	17%	16%
Өөрчлөгдөхгүй	23%	32%	33%	35%	33%	29%
Буурна	12%	14%	14%	13%	14%	14%
Их буурна	5%	2%	1%	2%	2%	1%
Мэдэхгүй/хариулаагүй	30%	26%	26%	27%	29%	33%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%

2025 оны судалгаагаар Монгол улс дахь авлига хамгийн их тархсан институтийн талаар асуухад, шүүх, газрын алба, төрийн захиргааны яам, агентлаг гэсэн хариултууд тэргүүлж байна. Энэ нь өмнөх оны үр дүнгээс нэлээд ялгаатай буюу өмнөх жил Нутгийн захиргааны байгууллага авлига өндөр тархсан хэмээн үнэлэгдэж байсан бол энэ онд 10 дугаар эрэмбэд байна. Харин газрын албан өмнөх онд төдийлөн авлига тархсан гэж иргэд үзээгүй бол энэ онд өөр төсөөлөлтэй байна. Энэ оны судалгаагаар газар, зохион байгуулалт, геодез, зураг зүйн газрын үнэлгээ хамгийн их бууралттай байгаа нь энэ үр дүнтэй адил байна.

Зураг 13. Монгол улс дахь авлига хамгийн их тархсан институци, 2024 болон 2025 он, хариултад эзлэх хувиар

№	Байгууллага	2024 оны эрэмбэ	2024	2025
1	Шүүх	4	7%	10%
2	Газрын алба	13	2%	10%
3	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	1	37%	10%
4	Улс төрийн нам	2	16%	9%
5	Эрүүл мэндийн байгууллага	10	2%	9%
6	Цагдаагийн байгууллага	5	6%	7%
7	Гаалийн байгууллага	12	2%	7%
8	Прокурорын байгууллага	7	4%	7%
9	Боловсролын байгууллага	8	3%	6%
10	Нутгийн захиргааны байгууллага	3	8%	6%
11	Хэвлэл мэдээллийн байгууллага	6	5%	5%
12	Татварын байгууллага	11	2%	5%
13	Мэргэжлийн хяналтын байгууллага	15	1%	4%
14	Төрийн бус байгууллага	9	3%	2%
15	Хувийн хэвшил	14	1%	2%
16	Бусад	16	2%	0%

Харин өмнөх онуудтай адил төрийн захиргааны байгууллага яам, агентлаг, улс төрийн нам, шүүх байгууллагууд эхний 5-д эрэмбэлэгдсэн байдал нь хадгалагдсан хэвээр байгаа нь эдгээр байгууллагуудын шударга байдалд иргэд эргэлзсэн хэвээр байгааг харуулж байна.

3.2 Монгол улс дахь авлигын шалтгаан

Судалгаанд оролцогчдоос Монгол улс дахь авлигын үндсэн шалтгааныг та юу гэж бодож байна вэ? гэсэн цалин хөлс бага, ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин доогуур,

хүнд суртал их, хувь хүний хандлага, шунал, ёс зүйн дутмаг байдал гэсэн хариултууд мөн л хамгийн олон давтамжтай хэвээр байна.


Хүснэгт 27. Монгол улс дахь авлигын үндсэн шалтгаан, 2025

№	Төрөл	Хариултад эзлэх хувь
1	Цалин хөлс бага	11.8%
2	Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлт	7.1%
3	Хүнд суртал их	5.9%
4	Хувь хүний хандлага, шунал, ёс зүй	5.8%
5	Танил тал, хамаатан садны холбоо (уламжлалт хандлага)	3.8%
6	Төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл их	3.0%
7	Ажлаа хурдан бүтээх хүсэл	3.0%
8	Эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл бий болсон	2.7%
9	Улс төр, бизнесийн бүлэглэл холилдсон	2.5%
10	Хяналт сул	2.3%
11	Шударга бус (ижил тэгш үйлчилдэггүй)	2.2%
12	Хариуцлага тооцдоггүй байдал	2.2%
13	Хууль тэгш үйлчилдэггүй, хуулиа мөрдөхгүй	2.1%
14	Ил тод бус байдал	2.1%
15	Ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс тухайн салбарт төрийн албанд ажилладаг	1.8%
16	Боловсрол муу (хуулийн мэдлэг АТГ-тай тэмцэх талаар мэдлэггүй)	1.7%
17	Тогтолцооны гажуудал	1.4%
18	Төрийн үйлчилгээний ачаалал их	1.3%
19	Холбогдох хууль тогтоомж зөрчилтэй, олон янзаар тайлбарладаг	1.3%
20	Гар цайлгах, уламжлал сэтгэлгээ	1.2%
21	Төрийн албан хаагчид чадваргүй	1.0%
22	Ажлын шат дамжлага олон (элдэв зөвшөөрөл маш их шаарддаг)	0.9%
23	Эрх зүйн орчин муу	0.9%
24	Иргэд өөрсдөө авлига өгдөг	0.7%
25	Сургалт мэдээллээр хангадаггүй	0.7%
26	Төрийн алба хаагчийн хариуцлагагүй байдал	0.5%
27	Татвар өндөр	0.5%
28	Төрийн байгууллага хангалттай цахимжаагүй	0.4%
29	Ажиллах орчин муу (удирдах албаны дарам шахалттай)	0.3%
30	АТГ мэдээлэл өгөх боломжуудыг нэмэгдүүлж, нууцлах	0.2%
31	Ажлын байрны чиг үүрэг тодорхойгүй	0.2%
32	Төрийн албан хаагчид тухайн ажлын байрандаа маш олон жил ажилласан байдаг нь	0.2%
33	АТГ-ын үйл ажиллагаа хангалтгүй	0.0%
34	Хариулаагүй/мэдэхгүй	28%

3.3 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг нийт судалгаанд оролцогчдын 38.5 хувь нь дунд зэрэг, 14.4 хувь нь үр ашиггүй, 13.2 хувь нь үр ашигтай, 9.1 хувь нь огт үр ашиггүй, 2.3 хувь нь ихээхэн үр ашигтай, 22.5 хувь нь мэдэхгүй гэж үнэлжээ.

Зураг 14. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг хэрхэн үнэлэх вэ?, сүүлийн 5 жилээр



Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг 2024 онтой харьцуулахад, ихээхэн үр ашигтай гэж үзсэн оролцогчдын хувь 0.7 пунктээр, үр ашигтай гэж үзсэн оролцогчдын хувь 2.4 пунктээр, үр ашиггүй гэж үзсэн хувь 2.6 пунктээр тус тус буурчээ. Харин дунд зэрэг гэж үнэлсэн хувь 4 пунктээр, огт үр ашиггүй гэж үзсэн хувь 1.7 пунктээр тус тус өссөн. Мэдэхгүй гэж хариулсан оролцогчдын хувь 2024 оноос өөрчлөгдөөгүй буюу их хувьтай хэвээр байна. Хариултуудыг дундаж оноонд шилжүүлбэл АТГ-ын үйл ажиллагааны үр ашгийг 45.2 гэж үнэлж байна¹⁰.

¹⁰ Ихээхэн үр ашигтай – 100, үр ашигтай – 75, дундаж – 50, үр ашиггүй – 25, огт үр ашиггүй – 0 оноо гэж үзнэ.

ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагын шударга байдал нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл төдийгүй, тухайн байгууллагын үр ашгийг дээшлүүлэх хүчин зүйл болдог. АТГ-ын ШБҮ-ний аргачлалын дагуу төрийн байгууллагаар үйлчлүүлж буй 10840 иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөллөөс тухайн байгууллагын ГШБ-г хэрхэн үнэлж байгааг асуусан судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг өгч байна. Ингэхдээ яам, агентлаг ба аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээгээр төрийн байгууллагуудын дундаж үнэлгээг тооцсон бол нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-уудын үнэлгээг тусад нь дүгнэсэн болно. Үүнд:

- Төрийн байгууллагуудын дундаж ГШБҮ нь 2025 онд 70.7 болж өмнөх оноос 1.6 оноогоор өссөн. Өөрчлөлтийг бүрэлдэхүүн индексээр задалж үзвэл авлигын эрсдэлийн индекс 2.1 оноогоор, авлигын индекс 1.2 оноогоор тус тус өссөн байлаа. Индексэд хамаарах дэд 5 үзүүлэлтийн оноо 59.7 – 84.3 -ийн хооронд үнэлгээтэй, үүнээс 4 дэд үзүүлэлт өсөлттэй, нэг нь төдийлөн өөрчлөлтгүй байна. Төрийн байгууллагын дунджаар ил тод байдал 58.5, хариуцлагатай байдал 64.1, авлигын талаарх төсөөлөл 62.3, авлигын шууд тохиолдол 84.2 ба авлигын шууд бус тохиолдол 83.8 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.
- ГШБҮ-ний нэгж асуултуудаас ил тод байдлын асуултууд (A1, A2), хариуцлагатай байдлын асуултууд (A3, A4), авлигын талаарх төсөөлөл (A5 – A10)-ийн асуултууд 58.9 – 69.0-ийн хооронд үнэлгээтэй буюу доогуур үнэлэгдэж байна. Авлигын шууд ба шууд бус тохиолдлын асуултууд харьцангуй өндөр буюу 69.9 – 95.6-ийн хооронд үнэлгээтэй байна. Эдгээрээс үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдал (60.6) , төсөв, санхүү, худалдан авалтын ил тод байдал (58.9), үйлчилгээ үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал (61.8), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (62.8) гэсэн асуултууд хамгийн бага үнэлгээтэй байна. Энэ үр дүн өмнөх жилд мөн адил байжээ.
- Төрийн байгууллагын төрлөөр авч үзвэл агентлагуудын ГШБҮ нь 76 буюу өмнөх оноос 4.5 оноогоор өссөн бол яамдын (ГШБҮ=68.8) болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын (ГШБҮ=63.9) үнэлгээ харгалзан 2.5 ба 1.2 оноогоор тус бүр буурсан байна. Дүүргийн ЗДТГ-уудыг оруулахгүйгээр нийт 72 байгууллагаас 38 байгууллагын үнэлгээ өсөж, 7 байгууллагын үнэлгээ төдийлөн өөрчлөлтгүй, үлдсэн 27 байгууллагын үнэлгээ буурсан.
- 2025 онд Оюуны өмчийн газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Монополын эсрэг газар болон Архивын ерөнхий газар гэсэн 5 байгууллага ГШБҮ-ний эрэмбэд тэргүүлж байна. Дээр дурдсан байгууллагуудаас Оюуны өмчийн газар 1 эрэмбэ урагшилж тэргүүлсэн бол бусад 4 байгууллага олон байр урагшилж эхний эрэмбүүдэд орсон байв.
- Харин Боловсролын яам, Ховд, Өвөрхангай, Дорнод ба Сүхбаатар аймгийн ЗДТГ-ууд ГШБҮ-ний хамгийн доод оноог авсан 5 байгууллага байв. Эдгээрээс Дорнод аймгийн ЗДТГ-ын эрэмбэ өмнөх оноос өөрчлөлтгүй байсан бол бусад 4 байгууллага олон эрэмбэ ухарсан үр дүнтэй байна.
 - Энэ оны эрэмбийн хамгийн сүүлд орсон Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 47.8 (12.5↓) хувьд үнэлгээний тооцоололд орох 20 асуултын 15 нь

60-аас доош үнэлгээтэй, үүнээс 11 нь 50-аас доош үнэлгээ авсан байна. Тус ЗДТГ-ын хувьд ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтүүд өмнөх онд мөн л бага үнэлгээтэй байсан бол энэ онд түүнээсээ дахин буурсан үр дүнтэй. Харин авлигын шууд тохиолдол тэр дундаа үйлчилгээ үзүүлэх нэмэлт төлбөр авах, бэлэг авах болон авлигын шууд бус тохиолдлын давтамж өмнөх оноос нэмэгдсэнээр эдгээр зүйлсийн үнэлгээ ихээр буурсан байлаа.

- Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 49.2 (21.7↓) оноотой, үнэлгээний тооцоололд орох 20 асуултын 14 нь 60-аас доош, түүнээс 6 нь 50-аас бага үнэлгээ тус тус үзүүлсэн. 13 үзүүлэлтийн үнэлгээ өмнөх оноос 20 ба түүнээс дээш дүнгээр буурсан нь анхаарал татахуйц байна. Улмаар тус байгууллага нь хамгийн их бууралттай байгууллагын нэг байна.
 - Дорнод аймгийн ЗДТГ-ын хувьд үнэлгээ өмнөх оноос өөрчлөлтгүй буюу 0.9 онооны буурч 49.3 гэсэн үнэлгээтэй байна. Энэ онд дэд үзүүлэлтүүдийн өсөлт, бууралт харилцан нэгнээ нөхөх шинжтэй үр дүнг үзүүлжээ. Тухайлбал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд тохиолдлын үзүүлэлтүүд сайжирсан ч эргээд ил тод байдал ба авлигын шууд бус тохиолдлыг үзүүлэлтүүд буурсан байна.
 - Ховд аймгийн ЗДТГ нь 51.6 (13.4↓) үнэлгээтэй, үнэлгээний тооцоололд орох 20 асуултын 9 нь 60-аас доош, түүнээс 7 нь 50-аас бага үнэлгээ тус тус үзүүлсэн. Тус ЗДТГ-ын хувьд ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд бус тохиолдлын үзүүлэлтүүд бүгд 10-аас дээш оноогоор буурсан байна.
 - Боловсролын яамны ГШБҮ нь 52.4 (9.0↓) үнэлгээтэй, үнэлгээний тооцоололд орох 20 асуултын 12 нь 60-аас доош үнэлгээтэй, үүнээс 7 нь 50-аас доош үнэлгээ авсан байна. Тус байгууллагын хувьд авлигын шууд бус тохиолдлоос бусад дэд үзүүлэлт бүгд буурсан ба үүнээс авлигын шууд тохиолдол 28.5 оноогоор буурч үнэлэгдсэн нь хамгийн их өөрчлөлтийг авчирсан байна.
- 2025 онд Үндэсний геологийн алба, Онцгой байдлын ерөнхий газар, Боловсролын газрын үнэлгээ хамгийн ихээр өссөн бол Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар, Өвөрхангай аймгийн ЗДТГ, Эрчим хүчний яамдын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 18.9 – 26.8 онооны хооронд тус тус буурсан байна.
 - Тооцоололд ашигласан эхний хүчин зүйл болох Авлигын эрсдэлийн индекс нь 63.4 оноогоор буюу өмнөх оноос 2.1 оноогоор өсөж үнэлэгдсэн байна. Хэдий тийм боловч жил бүрийн судалгаагаар авлигын эрсдэлийн индекс ийнхүү хангалтгүй түвшинд хэвээр байсаар байна. Энэ индекс нь тухайн байгууллагын ил тод байдал ба хариуцлагатай байдлын үнэлгээг харуулдаг ба 2025 онд харгалзан 59.7 ба 67 гэсэн үнэлгээтэй байна. Үнэлгээний асуулгад үйл ажиллагаа, хүний нөөц (60.6 оноо) ба төсөв санхүүгийн мэдээллийн (58.9) ил тод байдлыг лавладаг ба төрийн үйлчилгээ авч буй этгээд тэдгээрийг өөрийн авч буй үйлчилгээний хүрээнд сонирхож хайгаагүй бол мэдэхгүй байх тал өндөр байгааг анхаарах шаардлагатай. Хариуцлагатай байдлыг үйлчилгээ үзүүлэх үедээ хүчин чармайлт сайн гаргаж (66.6), ёс зүйн хэмжээг сахисан (67.5) эсэхийг тодруулж үнэлдэг ба

хэдийгээр өмнөх оноос өссөн боловч цаашид эдгээр талуудыг сайжруулах шаардлага байсаар байна.

- Үнэлгээний хоёр дахь хүчин зүйл болох авлигын индекс энэ онд 77.9 оноо буюу өмнөх оноос 1.2 оноогоор өсөж үнэлэгдсэн. Индексийн тооцоололд ашиглагддаг авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд тохиолдол, шууд бус тохиолдол зэрэг үзүүлэлтүүд нь харгалзан 65.6, 83.9, 84.3 гэсэн дундаж үнэлгээтэй ба авлигын шууд тохиолдол бараг өөрчлөлтгүй, бусад хоёр нь өмнөх оноос өссөн байна. Үүнээс авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт өмнөх жилүүдийн судалгаатай адил хангалтгүй түвшинд хэвээр байна. Үүнд төрийн үйлчилгээ үзүүлэх үед бусдад дарамт шахалт үзүүлэх, танил талын нөлөөнд автах, бусдад давуу байдал хууль бусаар олгох, шан харамж авах эсхүл өгөх, бүрэн эрхээ хэтрүүлэн эдлэх, хийх ёстой эсвэл ёсгүй үйлдлийг сахихгүй байх зэрэг шударга байдлыг зөрчсөн үйлдлүүд гарсаар байна гэж иргэд үзжээ. Авлигын шууд тохиолдлын төрлүүдийн талаарх асуултын үнэлгээ дийлэнх нь өмнөх оноос өсөлттэй гарсан буюу нэмэлт төлбөр өгөх, бэлэг өгөх, санхүүгийн туслалцаа үзүүлэх зэрэг үйлдлийн тохиолдол, давтамж, үнийн дүн ерөнхийдөө өмнөх оноос бага ажиглагдсан байна. Гэхдээ үйлчилгээ авах үедээ албан хаагчид өгсөн бэлгийн мөнгөн дүн өмнөх оноос өндөр байсан байна.
- Үйлчилгээ авах үедээ бэлэг, хандив, нэмэлт төлбөр өгөх явдал аймгийн ЗДТГ-ууд болон яамдын хувьд илүү олон байлаа. Эдгээр зүйлсийг ямар үед өгч байгааг тодруулсан асуултад үйлчилгээ авсны дараа (29.7%), үйлчилгээ авахаас (26.3%) өмнө ба авах үедээ (19.4%) гэсэн хариултауд өндөр хувьтай байна. Харин эдгээр үйлдлүүдийн шалтгаан нь ажлаа хурдан бүтээхийн тулд (31.4%), хариуцлагаас зайлсхийхийн тулд (26.5%), давуу байдал олж авахын тулд (16.8%) гэсэн шалтгаанууд мөн л энэ онд олноор дурдагдлаа. Эдгээр үйлдлийг таслан зогсоохын тулд дээр дурдсан шалтгааныг бий болгох нөхцөлийг байгууллага тус бүр олж харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Энэ оны судалгаагаар төрийн байгууллагуудын төрөл хооронд ГШБҮ-ний хувьд онцлог ялгаа байгаа эсэхийг нягталж үзвэл яамдын ГШБҮ 68.6 оноотой (3.2↓) хамгийн ихээр буурсан ба үнэлгээнд ашиглагддаг бүх 5 дэд үзүүлэлтүүд буурсан байв. Яамдын хувьд үйлчилгээ авахдаа төрийн албан хаагчид бэлэг өгдөг давтамж, мөнгөн дүн нэмэгдсэн байдал нь ийнхүү бага үнэлгээтэй гарахад хамгийн их нөлөөлсөн байсан. Цаашлаад аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ (63.9) төдийлөн өөрчлөлтгүй бол агентлагуудын үнэлгээ (76.0) 4.5 онооны өсөлттэй байлаа.
- ШБҮ-ний 2022 оны судалгаанаас эхлэн дүүргүүдийн ЗДТГ-уудыг хамруулж эхэлсэн ба судалгааны үр дүнг жилүүдээр харьцуулах үүднээс тусад нь тайлагнадаг. Дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ-ний дундаж 74.6 буюу өмнөх оноос 8.3 оноогоор өссөн.
- Дүүргүүдээс Хан Уул ба Сонгино хайрхан дүүргүүд хамгийн өндөр үнэлгээг авсан бол Чингэлтэй ба Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хамгийн бага үнэлгээг авчээ. ГШБҮ хамгийн их өсөлттэй нь Багахангай болон Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ууд байсан ба үнэлгээ нь буурсан байгууллага байсангүй.

- Энэ оны судалгаагаар ГШБҮ-ний бүрэлдэхүүн бүх үзүүлэлтүүд нийтлэгээр өссөн үр дүнтэй байна. Үүнд, нөлөөлсөн байж болох дараах хүчин зүйлс байна. Нэгдүгээрт, өмнөх он сонгуулийн жил байсантай холбоотойгоор асуулгад оролцогчдын хандлага бага үнэлгээ өгөх талтай байсан бол энэ жилд тэрхүү нөлөө арилсан гэж үзэж болно. Хоёрдугаарт, өмнөх жил тааруу үнэлгээ авсан эсвэл үнэлгээ буурсан байгууллагууд олон байсан бөгөөд тэдгээр нь шударга байдлыг бэхжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, ажиллан үр дүнд хүрсэн байх талтай. Эдгээр нийтлэг хүчин зүйлсээс гадна тухайн байгууллага тус бүр энэхүү тайлангийн дүгнэлт ба дэлгэрэнгүй хавсралтыг харж, үнэлгээний өөрчлөлтийн шалтгааныг дотоод үйл ажиллагааны хүчин зүйлсээс эрэлхийлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөвөл зохино.
- Энэ оны судалгаагаар иргэдийн дундах авлигын түгээмэл байдлын төсөөлөлд бага зэргийн эерэг өөрчлөлт ажиглагдсан ч дундаж үнэлгээгээр 32.7 гэсэн оноог өгч болохоор байгаа нь маш бага үнэлэмжтэй байгааг харуулж байна.
- Судалгаанд оролцогчдын Монгол Улсын ирэх хоёр жилийн авлигын түвшний төсөөлөлд өснө гэсэн төсөөлөл нэмэгдсэн байна. Тухайлбал, авлига их өснө, өснө эсвэл өөрчлөгдөхгүй гэсэн төсөөллийн хувь тус бүр нэмэгдэж, буурна гэсэн хариултуудын хувь буурсан байлаа. Авлигын хандлагын төсөөллийг 100 хүртэлх оноогоор илэрхийлбэл 45.7 гэсэн үнэлгээтэй байна. Цаашид авлигын шалтгаанд чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, иргэдийн энэхүү төсөөлөлд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулан судлах шаардлагатай.
- Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад Цалин хөлсний хэмжээ бага (11.8%), Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлтийн нөлөө (7.1%), Хүнд суртал их (5.9%), Хувь хүний хандлага, шунал, ёс зүйн шалтгаан (5.8%), Танил тал, хамаатан саданд давуу байдал олгодог (3.8%), Төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл их (3%), Ажлаа хурдан бүтээх хүсэл (3%), Эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл бий болсон (2.7%), Улс төр, бизнесийн бүлэглэл холилдсон (2.5%), Хяналт сул (2.3%) гэсэн хариултууд хамгийн их давтамжтай байна.
- Монгол улсад авлига хамгийн их тархсан институтийн талаарх асуултад өмнөх онуудтай адилаар Шүүх, Газрын алба, төрийн захиргааны яам, агентлаг гэсэн байгууллагууд хамгийн өндөр давтамжтай тодорхойлогдсон. Энэ нь өмнөх оны үр дүнгээс нэлээд ялгаатай буюу өмнөх жил Нутгийн захиргааны байгууллага авлига өндөр тархсан хэмээн үнэлэгдэж байсан бол энэ онд нутгийн захиргааны байгууллага 10 дугаар эрэмбэд байна. Харин газрын алба өмнөх онд төдийлөн авлига тархсан гэж иргэд үзээгүй бол энэ онд өөр төсөөлөлтэй байна. Энэ оны судалгаагаар газар, зохион байгуулалт, геодез, зураг зүйн газрын үнэлгээ хамгийн их бууралттай байгаа нь энэ үр дүнтэй адил байна. Шүүх байгууллагын хувьд иргэдийн итгэх итгэл бага байдаг онцлогтой субъект бөгөөд газрын алба нэгжүүдийн үйлчилгээ нь ачаалал ихтэй, шийдвэрлэх хугацаа их, давтан ирэх шаардлага гардаг байгууллага юм. Цаашид жил бүр ихээр давтагдан дурдагддаг байгууллагуудад шалтгааныг тодруулах, түүнийг засах, иргэдийн дундах ойлголтыг залруулах мэдээлэл хүргэх зэргээр ажиллавал зохистой.
- Судалгааны хүрээнд төрийн байгууллагаас үйлчилгээ авсан төлөөллөөс тухайн байгууллагын шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх хүрээнд

хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодруулахад хамгийн их давтагдсан 10 арга хэмжээгээр дараах зүйлсийг онцолсон. Үүнд:

- Авлига, ашиг сонирхлын талаар хийх, хуулийн мэдээллээр хангах
 - Цалин хангамж, орлогыг нэмэгдүүлэх,
 - Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах
 - Хяналтыг сайжруулах (байгууллагын дотоод хяналт, хараат бус хянал, аудиторын үйл ажиллагааг сайжруулах)
 - Улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах
 - Хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйтэй иргэдийг бий болгох
 - Хууль дүрмийг баримтлах, хүн бүрд тэгш үйлчилдэг байх
 - Шударга бус байдлыг бууруулах
 - Цахим үйлчилгээ нэвтрүүлж, хүний оролцоог багасгах
 - Хариуцлага тооцдог байх
- Судалгаанд оролцогчдоос Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг үнэлэх асуулгыг авсан ба ихээхэн үр ашигтай ба үр ашигтай гэж үзсэн хариултуудын хувь бага зэрэг бууралттай. Нийт судалгаа өгсөн иргэдийн 38.5% нь дунд зэрэг гэж үзсэн буюу тухайн хариулт 4 нэгж хувиар өссөн байв. Хариултыг 100 хүртэлх оноогоор дундаж оноонд шилжүүлбэл 45.2 гэсэн үнэлгээтэй гэж үзэж болно. АТГ-ын үйл ажиллагааны талаар “мэдэхгүй/хариулаагүй” гэсэн хариулт өмнөх онтой адилхан хувьтай байгаа нь тус байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл төдийлөн олон нийтэд хүрэхгүй байгааг илэрхийлж болно.
 - Цаашид судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд тухайн хариултын шалтгааныг тодруулах нэмэлт асуултууд оруулах, шударга байдлын гол ойлголтууд болох ил тод байдал ба хариуцлагатай байдлын асуултуудыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч болно. Түүнчлэн төрийн үйлчилгээ хэрэглэгчдээс тодруулж болох байгууллагын шударга байдлыг илэрхийлэх бусад үзүүлэлтүүдийг судлан нэмэгдүүлбэл зохино.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. ГШБҮ-ний нэгж асуултууд

Индекс	Дэд үзүүлэлтүүд	Нэгж асуултууд
Авлигын эрсдэлийн индекс	Ил тод байдал	A1. _____-ын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл нь ил тод байсан гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A2. _____-аар үйлчлүүлэхэд төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл нь ил тод байсан гэдэгтэй Та санал нийлэх үү?
	Хариуцлагатай байдал	A3. _____-ын алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргасан гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A4. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ёс зүйгүй үйлдэл гаргасан гэдэгтэй Та санал нийлэх үү?
Авлигын индекс	Авлигын талаарх төсөөлөл	A5. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A6. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A7. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгодог гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A8. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авсан, эсхүл өгсөн гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A9. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A10. _____-ний алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хувийн ашиг сонирхлын дагуу хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийсэн гэдэгтэй Та санал нийлэх үү?
	Авлигын шууд тохиолдол	A11. Та тухайн төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгсөн үү?
		A11-1. Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа өгсөн бэ?
		A11-2. Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээний үнэ, өртөгтэй байсан бэ?
		A12. Та тухайн төрийн албан хаагчид шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн үү?
		A12-1. Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа өгсөн бэ?
		A12-2. Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээний үнэ, өртөгтэй байсан бэ?
		A13. Та тухайн төрийн байгууллага, албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор хандив, бусад санхүүгийн туслалцаа үзүүлсэн үү?
		A13-1. Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа өгсөн бэ?
		A13-2. Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээний үнэ, өртөгтэй байсан бэ?
		A14. A11-A13-ын аль нэгд нь тийм гэж хариулсан бол дээр дурдсан зүйлсийг яг аль үед нь өгсөн бэ?
		A15. A11-A13-ын аль нэгд нь тийм гэж хариулсан бол дээр дурдсан зүйлсийг өгөх болсон шалтгаан нь юу вэ?
	Авлигын шууд бус тохиолдол	A16. Таны найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн _____-аас сүүлийн 12 сарын хугацаад үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж өгч байсныг мэдэх үү?
		A17. _____ байгууллага дахь авлигыг бууруулах, алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

		A18.Таны үнэлж буй _____-д авлигын нөлөө хэр байдаг вэ?
Монгол Улс дахь авлига		A19. Монгол Улсад авлига хэр түгээмэл байна вэ?
		A20. Монгол улсад авлига хамгийн их тархсан институт аль нь вэ?
		A21. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан нөхцөлийг Та нэрлэнэ үү.
		A22. Ирэх хоёр жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?
		A23. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх вэ?

Хавсралт 2. Судалгааны түүврийн хуваарилалт

№	Байгууллага	Түүврийн тоо
	Яамд	1840
1	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	120
2	Барилга хот байгуулалтын яам	120
3	Батлан хамгаалах яам	100
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	120
5	Гадаад харилцааны яам	120
6	Зам, тээвэр хөгжлийн яам	120
7	Сангийн яам	120
8	Соёлын яам	100
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	120
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	120
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	120
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	120
13	Эрүүл мэндийн яам	120
14	Эрчим хүчний яам	120
15	Эдийн засаг хөгжлийн яам	100
16	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	100
	Агентлаг	3720
1	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	100
2	Онцгой байдлын ерөнхий газар	100
3	Монополын газар	120
4	Стандарт, хэмжил зүйн газар	100
5	Цаг уур, орчны шинжилгээний газар	100
6	Гаалийн ерөнхий газар	120
7	Татварын ерөнхий газар	120
8	Цагдаагийн ерөнхий газар	120
9	Улсын бүртгэлийн ерөнхий газар	120
10	Архивын ерөнхий газар	120
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	120
12	Гадаадын иргэн харьяатын газар	100
13	Нийгмийн даатгалын ерөнхий газар	120
14	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	120
15	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	120
16	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	100
17	Биеийн тамир, спортын улсын хороо	100
18	Соёл урлагийн газар	100
19	Иргэний нисэхийн ерөнхий газар	100
20	Ашигт малтмал, газрын тосны газар	120
21	Мал эмнэлгийн ерөнхий газар	120
22	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	120
23	Оюуны өмчийн газар	100
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	120
25	Төрийн худалдан авах ажиллагааны газар	120
26	Усны газар	100
27	Үндэсний геологийн алба	100
28	Жижиг, дунд үйлдвэрийн газар	120
29	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	100
30	Боловсролын ерөнхий газар	100
31	Ойн газар	100
32	Шүүх шинжилгээний ерөнхий газар	100
33	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	100
34	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	100

	Аймгийн засаг даргын тамгын газар	5280
1	Архангай аймгийн ЗДТГ	180
2	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	180
3	Баянхонгор аймгийн ЗДТГ	180
4	Булган аймгийн ЗДТГ	180
5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	180
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	150
7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	180
8	Дорноговь аймгийн ЗДТГ	180
9	Дорнод аймгийн ЗДТГ	180
10	Дундговь аймгийн ЗДТГ	180
11	Завхан аймгийн ЗДТГ	180
12	Орхон аймгийн ЗДТГ	180
13	Өвөрхангай аймгийн ЗДТГ	180
14	Өмнөговь аймгийн ЗДТГ	180
15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	180
16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	180
17	Төв аймгийн ЗДТГ	180
18	Увс аймгийн ЗДТГ	180
19	Ховд аймгийн ЗДТГ	180
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	180
21	Хэнтий аймгийн ЗДТГ	180
22	Нийслэлийн ЗДТГ	180
	Дүүргийн ЗДТГ	
1	Багануур дүүргийн ЗДТГ	150
2	Багахангай дүүргийн ЗДТГ	150
3	Баянгол дүүргийн ЗДТГ	150
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	150
5	Налайх дүүргийн ЗДТГ	150
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	150
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	150
8	Хан-Уул дүүргийн ЗДТГ	150
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	150
	Нийт	10840

Хавсралт 3. ГШБҮ, индексүүд, дэд үзүүлэлтүүдийн 2025 оны үр дүн ба өөрчлөлт, байгууллагуудаар

Байгууллагууд	2025 оны эрэмбэ	2025 оны үнэлгээ								Өөрчлөлт							
		Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх тасалгал	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	47	60.2	69.7	64.9	62.9	81.4	68.3	70.8	67.9	16.3	23.5	19.9	18.4	9.3	7	11.6	15.7
Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	36	54.2	65.4	59.8	63.9	90.7	96.1	83.5	71.7	-8.5	-8.3	-8.4	-10.5	-8	1.9	-5.5	-7
Батлан хамгаалах яам	12	72	76.4	74.2	78.2	89.3	98.5	88.7	81.4	10.3	-0.8	4.7	2.3	24	12	12.8	8.8
Боловсролын яам	68	43.5	47.8	45.6	48.1	53.7	75.6	59.1	52.4	-10.5	-9.8	-10.2	-6.7	-28.5	11.5	-7.9	-9
Гадаад харилцааны яам	35	59.5	67.4	63.5	66.2	89.8	90.2	82.1	72.8	-10.5	-4.2	-7.3	-5.6	-9	-8.7	-7.8	-7.6
Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	53	53	59.1	56	59.3	61.7	93.3	71.4	63.7	-16.2	-14.5	-15.3	-15.8	-36.4	-4.2	-18.8	-17.1
Зам, тээврийн яам	52	50.9	63.2	57	57.4	73.3	82.4	71	64	3.4	2.6	3	-0.4	6.2	-4.7	0.4	1.7
Сангийн яам	43	55.4	61.5	58.4	65.2	87.3	87.2	79.9	69.2	-9	7.2	-0.9	19.7	10.2	25.9	18.6	8.9
Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам	37	58.4	65.1	61.7	63	89.5	92.2	81.5	71.6	-16	-6.8	-11.4	-9.1	8.6	-2.8	-1.1	-6.3
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	24	72.4	74.5	73.5	69.3	77.2	89.5	78.7	76.1	1.6	-3.1	-0.8	-8.9	-21.1	-9.1	-13	-6.9
Хууль зүй, дотоод хэргийн яам	25	65	69.5	67.2	68.6	95.2	90.7	84.8	76	-5.1	2.5	-1.3	-0.8	-0.4	-5.5	-2.2	-1.8
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	67	37.8	49.3	43.6	47.1	79.7	58	61.6	52.6	-8.3	-3.6	-5.9	-6.2	-18.2	-39.3	-21.2	-13.6
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	3	82.2	83	82.6	78.2	98.4	100	92.2	87.4	18.6	17.4	18	14.8	15.8	12	14.2	16.1
Эдийн засаг хөгжлийн яам	19	70.4	70.1	70.3	73.1	96.7	88.7	86.2	78.2	1.5	-1.6	-0.1	1.7	1.9	-2.5	0.4	0.2
Эрүүл мэндийн яам	66	46.9	51.4	49.2	51.2	38.3	81.6	57	53.1	-13.4	-6.6	-10	-2	-50.7	-5.5	-19.4	-14.7
Эрчим хүчний яам	61	50.8	58.1	54.5	58.3	71.6	64.6	64.8	59.6	-18.6	-14.3	-16.4	-13.5	-19	-31.8	-21.4	-18.9
Яамдын дундаж		58.3	64.5	61.4	63.1	79.6	84.8	75.8	68.6	-4	-1.3	-2.7	-1.4	-7.2	-2.7	-3.8	-3.2
Архивын ерөнхий газар	5	79.3	80.5	79.9	79.9	98.4	99	92.5	86.2	17.5	13.2	15.4	16	-1.1	-1	4.6	10
Ашигт малтмал, газрын тосны газар	60	54.4	59.7	57	56.1	66.7	65.6	62.8	59.9	4.5	8	6.3	8	-5.3	8	3.6	4.9
Биеийн тамир, спортын улсын хороо	34	60.8	68.2	64.5	67.3	84.7	92.1	81.4	72.9	-11.6	-5.8	-8.7	-7.2	-7.9	-4	-6.3	-7.5
Боловсролын ерөнхий газар	9	76	80.8	78.4	79.2	93	94.7	89	83.7	24.2	24.2	24.2	28.1	9.2	34.7	24	24.1
Гаалийн ерөнхий газар	38	57.5	70.1	63.8	69.3	78.7	88	78.7	71.2	-10.6	4.7	-3	5.3	10.4	10.1	8.6	2.8
Гадаадын иргэн харьяатын газар	31	64.9	71.1	68	69	85.8	87.3	80.7	74.3	-3.9	-1.7	-2.8	-2.3	-7.5	-3.3	-4.4	-3.6
Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн ерөнхий газар	55	32.5	65.1	48.8	53.9	96.5	83.3	77.9	63.4	-49.3	-23.2	-36.3	-31.5	-3.5	-16.7	-17.2	-26.8
Жижиг, дунд үйлдвэрийн газар	48	60.9	63.3	62.1	58.9	90	71.1	73.3	67.7	5.6	-15.8	-5.1	-22.5	-8.8	-28.9	-20.1	-12.6
Иргэний нисэхийн ерөнхий газар	40	56.7	64.9	60.8	66.3	96	78.6	80.3	70.6	-4.7	3.6	-0.5	4.6	2.4	-10.2	-1.1	-0.8
Мал эмнэлгийн ерөнхий газар	45	41.8	66.2	54	64.7	98.1	88.9	83.9	68.9	-5.3	-0.7	-3	5.2	8.7	-7.7	2	-0.5
Монополын эсрэг газар	4	78.9	79.8	79.3	82.7	100	99.1	93.9	86.6	22.9	14.6	18.7	19	3.8	8.5	10.4	14.6

Нийгмийн даатгалын ерөнхий газар	7	71.8	80.5	76.2	80.6	98.3	100	93	84.6	15.9	17.3	16.6	18.9	4.8	7	10.2	13.4
Ойн газар	20	68.2	71.9	70	74.1	96.1	88.9	86.4	78.2	7.7	2.4	5	10.9	-1.6	7	5.4	5.2
Онцгой байдлын ерөнхий газар	8	71.7	79.9	75.8	81	95.2	98.7	91.6	83.7	27.9	28.5	28.2	39.3	15.9	8.8	21.3	24.8
Оюуны өмчийн газар	1	82.9	85.2	84	89.7	100	100	96.6	90.3	2.3	0.7	1.5	4.4	0	1.3	1.9	1.7
Соёл урлагийн газар	57	51.4	57.3	54.3	60.5	74.8	68.3	67.8	61.1	-0.8	-4.2	-2.5	-11.2	-23.1	-30.6	-21.6	-12.1
Стандарт, хэмжил зүйн газар	26	64.3	76.4	70.4	75	79	90.8	81.6	76	6.7	11.4	9	14.2	-17.8	-4.8	-2.8	3.1
Татварын ерөнхий газар	27	60.5	68.5	64.5	69.8	95.2	92.9	86	75.2	7.7	9.7	8.7	17	16	30.2	21.1	14.9
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	6	76.9	76.7	76.8	78.5	100	100	92.8	84.8	13.3	7.1	10.2	10.3	3.1	12	8.4	9.3
Төрийн худалдан авах ажиллагааны газар	28	61.8	64.6	63.2	66.6	94.8	98.3	86.6	74.9	6.6	12.6	9.6	13.4	-1.6	2.5	4.8	7.2
Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	2	84.3	84.6	84.4	83.7	97.9	100	93.9	89.2	31.8	19.1	25.5	21.4	13.5	12.8	15.9	20.7
Улсын бүртгэлийн ерөнхий газар	42	44.9	68.1	56.5	67.5	91.8	87.8	82.4	69.4	-14.1	-3.7	-8.9	-3.3	2	-3.7	-1.6	-5.3
Усны газар	32	60.7	66.8	63.8	69.2	95.3	89.1	84.5	74.1	-5	-4.7	-4.9	-2.3	-4.7	-10.9	-6	-5.4
Үндэсний геологийн алба	22	67.2	70.4	68.8	66.3	92.8	97.2	85.4	77.1	26.6	22.3	24.5	22.7	38.5	38	33	28.7
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	41	61.6	75.9	68.8	69.7	57.1	86	70.9	69.9	3.1	7	5	-1	-42.9	-11	-18.3	-6.6
Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	30	55.7	73.1	64.4	70	94.5	90.4	84.9	74.7	-11.3	0.5	-5.4	-2.9	1.2	-4.6	-2.1	-3.8
Хөрөнгө оруулалт, худалдааны газар	49	60.8	64.9	62.8	48.8	84.3	80.7	71.2	67	11.7	-0.2	5.8	-28.4	-2.6	6.3	-8.2	-1.2
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	14	70.7	75.3	73	74.7	95.1	92	87.3	80.1	4.6	4.1	4.4	1.3	18.5	6	8.6	6.5
Цаг уур, орчны шинжилгээний газар	10	72.8	74.8	73.8	78.4	100	98.9	92.4	83.1	22.4	16.5	19.4	18.3	0	-1.1	5.7	12.6
Цагдаагийн ерөнхий газар	29	60.3	72.4	66.4	70.8	93.4	85.4	83.2	74.8	6.2	13.4	9.8	14.2	4.4	-2.7	5.3	7.6
Шүүх шинжилгээний ерөнхий газар	39	59.6	66.1	62.8	65.3	76.7	96.3	79.4	71.1	-0.5	-0.2	-0.4	-2.6	-2.9	9.7	1.4	0.5
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	21	65.2	74.6	69.9	74.2	97.5	85	85.6	77.7	-3.8	9.6	2.9	4.6	18.6	-7.6	5.2	4
